

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2019 ОНЫ 2 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.03.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 дугаар сард 1 удаа хуралдаж, 8 асуудал хэлэлцэн 9 тогтоол баталсан байна. Үүнд:

1.Ой тэмдэглэх зөвшөөрлийн тухай хэлэлцээд Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн үүсч байгуулагдсаны 60 жилийн ойг 2019 оны 10 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрөв.

2.Санал дэмжих тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Цагдаагийн газар нь ажлын үр дүн, амжилт бүтээлээрээ Монголын Цагдаагийн байгууллагын хэмжээнд удаа дараа тэргүүний байгууллага, хамт олноор шалгарч хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ирснийг нь үнэлж 2019 онд тохиох тус Цагдаагийн газрын түүхт 95 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын төрийн дээд шагнал “Цэргийн гавьяаны одон”-оор шагнуулах саналыг дэмжин Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдад уламжиллаа.

3.Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж, хөдөлмөрийн амжилт гаргасныг нь үнэлж Баруунбүрэн сумын ахмад настан Жачингийн Янживыг Монгол Улсын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

4.Хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн салбарын бодлого боловсруулах, хэрэгжилтийг удирдан зохион байгуулахад мэргэжлийн ур чадвар, бүтээлч санаачилга гарган ажилласныг нь үнэлж Монголын Тариаланчдын үндэсний холбооны тэргүүлэгч, Хушаат сумын Өгөөж Мандал Уул компанийн ерөнхий захирал Чүлтэмийн Пэрэнлэйг Монгол улсын “Гавьяат эдийн засагч” цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

5.Атрын I, II, III аянд биечлэн оролцож, газар тариалангийн үйлдвэрлэлийг бие даасан салбар болгон хөгжихөд сангийн аж ахуй, хамт олныг удирдан чиглүүлж, мэргэжлийн боловсон хүчнийг сургахад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, техник технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлсэн амжилтыг нь үнэлж Ерөө сумын Моностойн нуруу компанийн зөвлөх Бадарчийн Пүрэвжавыг Монгол Улсын “Гавьяат эдийн засагч” цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

6.Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Түшиг сумын “Бооцын тариа” компанийн зөвлөх агрономич Сайнхүүгийн Санжсүрэнг Монгол Улсын “Гавьяат агрономич” цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

7.Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Зүүнбүрэн сумын Бүрэн тал компанийн захирал Чойндонгийн Нямжавыг МУ-ын “Гавьяат агрономич” цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

8.Эрхэлсэн ажилдаа амжилт бүтээл гаргасан зарим иргэдийг одон медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 4, Алтан гадас одонгоор 5, Хөдөлмөрийн хүндэт медалиар 6 иргэнийг шагнуулаар уламжлав.

9.Оюуны спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд авъяас чадвараа дайчлан, тив дэлхийн хэмжээний тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож улс, аймгийнхаа нэрийг дуурсгаж явааг нь өндрөөр үнэлж Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын харъяат, олон улсын шатрын холбооны мастер Алтан-Өлзийн Энхтуулыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

Тэргүүлэгчид аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2018 онд зохион байгуулсан хяналт шалгалтын ажлууд түүний үр дүнгийн тухай аймгийн МХГ-ын даргын мэдээлэл, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай Хүдэр, Ерөө, Жавхлант сумдын Засаг дарга нарын мэдээллийг сонсож, бүрэн эрхийн үлдэж буй богино хугацаанд дээрх үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үр дүнтэй гүйцэтгэн ажиллахыг даалгалаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Газар тариалангийн өлгий нутаг Сэлэнгэ түмэн энэ онд атрын анхны шанг татсаны түүхт 60 жилийн ойгоо тэмдэглэх бөгөөд энэхүү ажлын хүрээнд МҮОНТВ-тэй хамтран “АТРЫН НУТГИЙН АМАР МЭНД” нэвтрүүлгийг Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан зохион байгууллаа. Нэвтрүүлгийг 2019 оны 02 дугаар 06-ны 18:35 цагаас МҮОНТВ-ээр үзэгчдийн хүртээл болголоо.

Билгийн тооллын хаврын тэргүүн сар Цагаан сарын шинийг бөхийн барилдаанд Улсын аварга 1, Улсын начин 1, аймгийн арслан 1, аймгийн заан 1, аймгийн начин 7, сумын заан 8, сумын начин 1, залуу бөх 12 оролцон барилдсанаас Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат ОБЕГ-ын Аврагч техник спорт хорооны бөх Улсын аварга Гунаажавын Эрхэмбаяр түрүүлж, Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын харьяат, «Таванбогдын бүргэдүүд» дэвжээний бөх улсын начин Бередмуратын Серик үзүүрлсэн. Мөн ахмад бөхчүүд, сурчид, уяачдад аймгийн Засаг дарга хүндэтгэл үзүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр “Улсын аварга малчин”-аар шалгарсан Орхонтуул сумын Баянцогт багийн малчин Х.Батсүх, Хүдэр сумын малчин Н.Цогнэмэх, Ерөө сумын малчин С.Түмэн-Өлзий, “Улсын аварга тариаланч хамт олон”-оор шалгарсан Баянгол сумын “Түмэн бут” ХХК, Хушаат сумын “Мо Мо Агро” ХХК, “Улсын аварга тариаланч”-аар шалгарсан Мандал сумын иргэн Б.Анхтөр, Цагааннуур сумын “Товхонхан” ХХК-ийн механикжуулагч Д.Алтанхуяг нарын шагналыг тус аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд болон аймаг, сумын удирдлагууд гардуулан өгч хүндэтгэл үзүүлсэн.

Мөн энэ үеэр Аймгийн аварга тариаланч хамт олон, аварга тариаланч, аварга ногоочин, аймгийн шилдэг уяач, аймгийн аварга малчин, аймгийн аварга фермерээр шалгарсан хүмүүсийн шагналын гардууллаа.

2019 онд нийт 724889 эх мал төллөхөөс 02 дугаар сарын 25-ны байдлаар нийт 2421 мал төллөж үүнээс гүү 14, үнээ 521, эм хонь 1044, эм ямаа 842 төллөөд байна. үүнээс унага 14, тугал 521, хурга 1044, ишиг 842 төллөсөн байна. Хорогдсон төл байхгүй байна. Том малын зүй бус хорогдол нийт 48 үүнээс адуу 10, үхэр 22, хонь 16, ямаа 11 үүнээс хээлтэгч мал нийт 96 үүнээс гүү 1, үнээ 8, эм хонь 19, эм ямаа 16 зүй бусаар хорогдсон мэдээтэй байна.

Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин энэ сарын 26-ны өдөр Сэлэнгэ аймгийн Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагаатай танилцлаа. Ажлын бүрэлдэхүүнд Азийн хөгжлийн банкны төслийн баг ажиллаж, Алтанбулаг сумын хилийн боомтын барилга, замын өргөтгөл, шинэчлэлт гэсэн 27 сая ам.долларын ажлыг энэ 4 сараас эхлэх бөгөөд дөрвөн эгнээтэй стандартад нийцсэн замын зургийг танилцуулсан. Энэ ажлынхаа хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагаа, төрийн байгууллага, иргэд, бас хөрөнгө оруулагч компаниудын удирдлагуудтай уулзсан. Мөн аймгийн Онцгой комиссыг хуралдуулж, цаг үеийн нөхцөл байдал, хаврын хуурайшилт эрт эхэлж ой хээрийн түймэр гарах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан ой хээрийн түймрийг гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, эргүүл постыг ажиллуулах, түймэр гарсан тохиолдолд аймаг, сум орон нутаг, онцгой байдлын байгууллагууд унтраах арга хэмжээг богино хугацаанд зохион байгуулах, түймэртэй тэмцэх хүн хүч техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг үүрэг болголоо.

Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд МАСАТО ТАКАОКА албаны айлчлал хийлээ. Ноён элчин сайдыг “Өвсний үндэс” хөтөлбөрийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүд дагалдан ирсэн бөгөөд уулзалтын үеэр найрамдалт харилцаа өргөжин тэлж, үр дүнгээ өгч байгааг хоёр тал онцолсон бөгөөд “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлын хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл”-ийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурлаа.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар

Тайлант сард хэлтсийн дотоод сургалтын төлөвлөгөөг хэлтсийн даргын А/02 тоот тушаалаар баталгаажуулан, төлөвлгөөний дагуу “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт”, “Албан хэрэг хөтлөлт”, “Цусны даралтаа зөв хэмжиж сурцгаая”, “Хоол үйлдвэрлэлийн зохистой дадал”, “Харилцааны сэтгэл зүй” зэрэг 5 сэдвээр сургалт, мэдээлэл хийн, хэлтсийн ажилтнуудыг бүрэн хамруулж, хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын 2019 оны гэрээг “Тэс Петролиум”, “Сод Монгол” ХХК, “СББ” ХХК, Орхонтуул сумын “Саруул” ШТС-тай тус тус байгуулсан.

Стандарт, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр Мандал, Сайхан, Баянгол, Алтанбулаг, Сүхбаатар сум, Дулаанхаан тосгоны 9 аж ахуйн нэгж, иргэний 5 хүнсний дэлгүүр, 1 минимаркет, 2 караоке баар, 1 гэрэл зургийн үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Гэрэл зургийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5375:2004” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Мөн Шаамар сумын “Аргангат” нөхөрлөлийн ирүүлсэн “Шижир” нэрийн зөгийн балыг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн сорилтын лабораторит шинжлүүлж, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж өглөө. “Алтан тариа” ХХК-ийн үйлдвэрлэж буй савласан сүү, тараг, цөцгий зэрэг бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг хянаж холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулах талаар зөвлөгөө өгч хамтран ажилласан.

Стандартын салбар сангаас 2 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 2 нэрийн 2 стандартын борлуулалт хийж, мэдээлэл аргагүйн зөвлөгөө өгсөн. Мөн аймгийн Хилийн мэргэжлийн хяналтын албаны захиалгын дагуу 19 нэрийн 19 стандартаар хангаж, мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгч, нийт 3 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 21 нэрийн 21 стандартын борлуулалт хийсэн байна. Баталгаажуулалтын албаны захиалгын дагуу 2 нэрийн 2 стандартаар хангах үйлчилгээ үзүүлсэн байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Сангийн яамнаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн тайланг гаргахаар 17 сум, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас тайланг нэгтгэж хүлээн авч байна. 2018 оны аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн тайлан хүлээн авч дууслаа. Аймгийн хэмжээнд нийт 1843 аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлан тушаахаас 1479 аж ахуйн нэгж, байгууллага тайлангаа ирүүлсэн бөгөөд ирц 80.3 хувьтай нэгтгэгдлээ.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	1,131,084.5	1,302,257.6	115.1
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	791,365.3	945,867.3	119.5

2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	5,925,262.7	4,065,961.9	68.6
	Үүнээс: ТЗШ байгууллагын зарлага	3,949,351.5	2,716,629.2	68.8
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	1,055,779.3	853,631.9	80.9
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	25,150.3	25,150.3	100.0
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт			
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт			
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	94,375.8	94,375.8	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	450,000.0	450,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	3,944,168.9	3,944,168.9	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	1,929,093.2	1,929,093.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	1,046,429.6	1,046,429.6	100.0
	- Соёлын байгууллага	288,573.2	288,573.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	111,624.1	111,624.1	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	522,059.2	522,059.2	100.0
	- ГХБХБГазар	18,868.0	18,868.0	100.0
- ГБХЗХГазар	27,521.6	27,521.6	100.0	
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	3,944,168.9	3,940,785.2	99.9
	- Ерөнхий боловсролын сургууль	1,929,093.2	1,929,093.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	1,046,429.6	1,046,429.6	100.0
	- Соёлын байгууллага	288,573.2	288,573.2	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	111,624.1	108,240.4	97.0
	- Эрүүл мэндийн байгууллага	522,059.2	522,059.2	100.0
	- ГХБХБГазар	18,868.0	18,868.0	100.0
- ГБХЗХГазар	27,521.6	27,521.6	100.0	
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	283,817.3	283,817.3	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	69,225.5	69,225.5	100.0
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	51,190.1	64,728.5	126.4
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	30,000.0	43,538.4	145.1
11	Тусгай сангуудын зарлага			#DIV/0!

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2018 XII - сар	2019 I- сар	2019-I 2018-XII /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА			
1 Талх, гурил, будаа			
Гурил /савласан, кг/	1200	1200	
Талх /орон нутгийн, ш/	1100	1100	
Нарийн боов /кг/	1900	2000	+100
Будаа /кг/	2400	2400	
Элсэн чихэр /кг/	2300	2200	-100
2 МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
Хонины мах /кг/	4500	5000	+500

	Үхрийн мах /кг/	5500	6500	+1000
	Адууны мах /кг/	4500	5500	+1000
	Ямааны мах /кг/	3000	4000	+1000
	Дотор мах, цувдай /цусгүй/	3000	3000	
	Хиам /чанасан, кг/	9800	10000	+200
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1400	1500	+100
	Сүү / савласан, л/	2500	2500	
	Тараг /задгай, л/	1500	1800	+300
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	11000	12000	+1000
	Айраг /л/	3500	3500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	
	Өндөг /ш/	300	320	+20
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3400	3400	
	Өөхөн тос /кг/	1500	1800	+300
	Шар тос /кг/	10000	10000	
	Масло /задгай, кг/	5000	5000	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	800	
	Лууван /кг/	600	600	
	Манжин /кг/	800	1000	+200
	Байцаа /кг/	1000	1500	+500
	Сонгино /кг/	1500	2000	+500
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3200	3200	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2000	2500	+500
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1450	1450	
	Бензин А - 92	1530	1530	
	Дизелийн түлш	1640	1690	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

2018 оны ХАСХОМэдүүлгийн тайланг аймгийн хэмжээнд нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлжээ. 2018 оны ХАСХОМэдүүлгийг нийт 292 нийтийн албан тушаалтан гаргасан байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 02 дугаар сард 146 гэмт хэрэг бүртгэгдэж 9.5 хувиар урьд оны мөн үеэс өсч, гэмт хэргийн илрүүлэлт 18,7 хувьтай, 4530 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн нь 1180 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 35,2 хувиар өссөн байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 2 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 139, лавлагаа 1 бичиж, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 67, лавлагаа 2 олгож үйлчиллээ.

2 дугаар сард иргэний бүртгэлийн талаар:

- ✓ Төрсний бүртгэл – 201 /эрэгтэй-104, эмэгтэй-97/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 36
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 7
- ✓ Эцэг тогтоолт – 7
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 6
- ✓ Нас баралт – 51
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 15
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 15
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 46

- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 143
- ✓ Гадаад паспорт олголт – 60
- ✓ ОХУ-ын хавсралт - 2056
- ✓ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 153
- ✓ Хот доторх шилжилт хөдөлгөөн – 286 тус тус бүртгэгдсэн байна.

Архивын чиглэлээр

Архивын Ерөнхий газраас ирүүлсэн албан тоотын дагуу Хосгүй үнэт баримтанд оруулах 9 баримтын жагсаалтыг Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Түшиг, Сант сумын ЗДТГ-ын нийт 50 хадгаламжийн нэгжний 4753 хуудас баримтанд мастер хувь үүсгэсэн. Мөн хөмрөгийн 55 хадгаламжийн нэгжийн 6155 хуудас баримтын мэдээллийн агуулгыг уншиж хүний нэр-19623, байгууллагын нэр-2404, газар зүйн нэр-2429, заалт-4937 шивж эх баримттай нь холбох ажлыг хийсэн.

Албан байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу архивын магадлагаа, тодорхойлолт 30, малчин даатгуулагчид олгох архивын лавлагаа 1, иргэдэд ажилласан жилийн холбогдолтой архивын хуулбарыг цахим хувиас 116, мастер хувиас 24, цаасан суурьтай баримтаас 33 буюу нийт 173 лавлагаа гаргаж үйлчилсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр

2018-2019 оны хичээлийн жилийн орос хэлний хичээлийн Улсын олимпиадын 2-ын давааг Сүхбаатар сумын 3-р сургууль дээр зохион байгуулж олимпиадыг 9, 12-р ангийн сурагчид болон багш нарын нийт 3 ангилалаар явагдаж 47 сурагч, 34 багш оролцсон. Үүнээс: 9-р ангийн сурагчдын ангилалд 33 сурагч, 12-р ангийн сурагчдын ангилалд 14 сурагч оролцлоо. 9-р ангийн сурагчдын ангилалд Сүхбаатар сумын УТ-ний 4-р сургуулийн сурагч О.Нандин-Эрдэнэ 1-р байр, Орхон сумын ЕБС сурагч Э.Энхжин 2-р байр, Мандал сумын “Билиг ДБ” сургуулийн сурагч О.Отгон-Эрдэнэ 3-р байр, 12-р ангийн сурагчдын ангилалд Сайхан ЕБС-ийн сурагч Ю.Мөнхтунгалаг 1-р байр, Ерөө сумын ЕБС-ийн сурагч Д.Мөнхсэлэнгэ 2-р байр, Мандал сумын “Билиг ДБ” сургуулийн сурагч Б.Хосзаяа 3-р байр, багш нарын ангилалд Сайхан ЕБС-ийн багш Э.Оюун-Эрдэнэ 1-р байр, Ерөө сумын ЕБС-ийн багш Г.Цэцэгмаа 2-р байр, Сүхбаатар сумын УТ-ний 4-р сургуулийн багш Д.Энхтуяа 3-р байрыг тус тус эзэлсэн.

Дэлхийн зөн монгол ОУБ-тай хамтран “Хүмүүжлийн эерэг арга аргачлал” сургалтыг Жавхлант суманд зохион байгуулж цэцэрлэгийн 40 туслах багш нар хамрагдсан. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр БСШУСЯ-аас хэрэгжүүлж буй “БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ШИНЭЧЛЭЛ” төслийн хүрээнд аймгийн төв болон сумын сургуулийн бага ангийн бүлэг бүрт ангийн номын санд зориулан 282,1 сая төгрөгийн 25834 ширхэг хүүхдийн ном нийлүүлэгдсэнийг сургуулиудад хуваарийн дагуу хүргүүлсэн. Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг эхлүүлж аймгийн Нэгдсэн музейн нийт 3236 үзмэрийг тоолсон. Тооллогын явцад өмнөх тооллогын үед гаргасан алдаа засварлах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийн жагсаалтыг гарган улсын комисст шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогод Бэлчир бүсийн Соёлын төвийн орон нутаг сурталчлах танхимыг хамруулсан. Хэвлэлийн үйлдвэрүүдээс 7509 ширхэг сурах бичгийг хүлээн авч, 34 сургуульд хувиарын дагуу олгож байна.

“Үндэсний цом-2019” насанд хүрэгчдийн футзалны Улсын аварга шалгаруулах тэмцээнд 18 аймгийн 200 гаруй тамирчид өрсөлдөж дэд шатны ангилалд Дархан-уул аймаг тэргүүлж Орхон, Сэлэнгэ аймаг удаалсан. 1-р шатны ангилалд Баян-өлгий аймаг тэргүүлж Увс, Сүхбаатар аймгууд удаалж, шилдэг хаалгач дэд шатны ангилалд

Дархан-Уул аймгийн тамирчин Ж.Энхбаяр, 1 шатны ангилалд Увс аймгийн тамирчин Ж.Дашням, шилдэг довтолгооч дэд шатны ангилалд Орхон аймгийн тамирчин Ц.Мөнх-эрдэнэ, 1 шатны ангилалд Баянөлгий аймгийн тамирчин Б.Антон, шилдэг тоглогчдэд шатны ангилалд Сэлэнгэ аймгийн тамирчин Г.Батболд, 1 шатны ангилалд Баянөлгий аймгийн тамирчин Н.Тильсаншилдэг шүүгчээр Г.Нарангэрэл нар шалгарсан.

Аймгийн аварга шалгаруулах пауэрлифтингийн тэмцээнийг цэргийн хүчний 7 байгууллагуудын дунд зохион байгуулж 80 гаруй тамирчид оролцон багийн дүнгээр тэргүүн байр Цагдаагийн газар, дэд байр ХЦ-ийн 0101-р анги, аймгийн Онцгой байдлын газар эхний 3 байранд шалгарсан.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар

2019 оны 01-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 776 байсан бол 221 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 109 ажлын байранд 47 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 197 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 753 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 2 сарын байдлаар 21,405 иргэнд 2,518,974.5 мянган төгрөгийг олгосон.

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2,115 иргэнд 634,023.9 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1,325 иргэнд 176,406.3 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 918 иргэнд 76,555.0 мянган төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 89 иргэнд 17,055.3 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 184 иргэнд 27,567.2 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 807 эхэд 31,514.0 мянган төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 36 иргэнд 6,510.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 7,493 иргэнд 995,300.0 мянган төгрөг
- Насны хишиг 4,081 иргэнд 322,420.0 төгрөг
- Цалинтай ээж хөтөлбөр 4,357 иргэнд 231,622.8 мянган төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 7080 иргэд 946,702.8 мянган төгрөгийг тус тус олгосон.

Ахмад настны тухай хуулийн 12-р зүйлийн 12.5 дахь заалтын дагуу ажиллаж байсан аж ахуй нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан, өөр орон нутгаас шилжиж ирснээс харьяалах байгууллагагүй болсон ахмад настануудыг билгийн тооллын хаврын тэргүүн сар Цагаан сарын шинийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Үүнд 15 сумын 1600 ахмад настанд Нийгмийн халамжийн сангаас 16,000.0 мянган төгрөгийг зарцуулсан. Хүндэтгэлийн арга хэмжээнд ирсэн ахмад настануудад эрүүл мэндийн газартай хамтран үзлэг оношлогоо хийж үйлчилгээ үзүүлсэн.

3.Эрүүл мэндийн талаар

Орхон сумын Эрүүл мэндийн төвийн эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт үнэлгээ хийж, амьгүй төрөлт, нярайн эндэглийг магадлан хэлэлцэх хурал болон бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сум, Рашаант, Номгон тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга эх баригч нарын 28 хүн хамрагдсан.

Баянгол сумын Эрүүл мэндийн төвийн эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт үнэлгээ хийж, тав хүртэлх насны хүүхдийн эндэглийг магадлан хэлэлцэх хурал зохион байгуулсан. Магадлан хэлэлцэх хуралд Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч, эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмч, Түнхэл, Хэрх тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга эх баригч нарын 24 хүн хамрагдсан. Хушаат суманд эндсэн нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх бүсийн

сургалтыг зохион байгуулж Шаамар, Хүдэр, Ерөө, Жавхлант, Баянгол сум, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга нар, эх баригч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудын хамт 35 хүн оролцлоо. Хушаат сумын Амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх хурлаас гарсан санал, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гарган хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна. Ерөө сумын 2019 оны 01 сарын 04-ны өдөр эндсэн эхийн эндэгдлийг магадлан хэлэлцэх эмнэлзүй, эмгэг судлалын хуралд Эрүүл мэндийн газрын дарга, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эх баригч нарын 70 хүн хамрагдсан.

“Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд хамт олны оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг Баянгол суманд ХӨСҮТ, ЭМГ, сумын ЗДТГ, ЭМТ, ЕБС, цэцэрлэгийн багш удирдлагууд болон суманд үйл ажиллагаагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудын нийт 34 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 4 дуудлага ирж хамтарсан багийн хариу үйлчилгээ үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал 2 удаа хуралдаж, 54 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлсон. Албадлагын арга хэмжээ авагдсан 7 хүүхдэд 2 цагийн амьдрах ухааны хичээлийг заалаа.

Гэр бүлийн “Хүндэтгэлийн танхим”-аар 2 залуу хосын гэрлэлтийн батламжийг гардуулж, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын зөвлөмж, үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1, зан төлөвийн өөрчлөлттэй 1 хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн. Алтанбулаг, Мандал сумдын “Түр хамгаалах байр”-ны нийгмийн ажилтан, үйлчилгээний ажилтнуудад арга зүйн сургалт хийсэн. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч Бугант тосгоны С-ийг Алтанбулаг сумын “Түр хамгаалах” байранд хүргэж, хамтарсан багийн үйлчилгээ үзүүлсэн. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ ОНХХ, Хүүхдийн эрх хамгааллын төвтэй хамтран “Нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах” сургалтыг зохион байгуулж сургалтад 17 сум 6 тосгоны Нийгмийн бодлого, эрүүл мэнд, боловсрол, халамж хариуцсан нийт 111 нийгмийн ажилтнууд хамрагдсан.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2019 оны 02 сарын байдлаар 26.7 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 02 дугаарсарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 25.3 тэр бум төгрөгний орлого төвлөрүүлж 94.58 хувийн биелэлттэй ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 02 сард 222 иргэд, даатгуулагчдад гарган түргэн шуурхай үйлчилсэн.

Тэтгэврийн даатгалын сангаас 16576 тэтгэвэр авагчдад 5431.1 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 627 хүнд 170.2сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 220 хүнд 92.5 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 38 хүнд 51.5 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, албадын дарга нар хамрагдаж, 2018 оны ажлаа дүгнүүлж, 2019 оны зорилго зорилтоо тодорхойлон ХХААХҮЯ-ны сайдтай хамтран ажиллах үр дүнгийн гэрээг байгуулсан.

Аймгийн хүн амын дунд давсны зөв зохистой хэрэглээг хэвшүүлэх, иоджуулсан давсны ач холбогдлыг сурталчлах, давс багатай хүнс болон хоол үйлдвэрлэлийн

бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяныг өрнүүлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл, урлагын газар, аймгийн Тогоочдын холбооны төлөөллийг оролцуулан хурал зохион байгуулж аяны танилцуулга хийж, аймгийн хэмжээнд аян зохион байгуулах ажилд санал авч нэгтгэн аймгийн Засаг даргын А/25 тоот захирамжийг гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулсан. “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аян, давсны хэрэглээ, давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн нийт 144 ширхэг тараах материалыг 17 сумдын салбарын төлөөлөл, холбогдох агентлагуудад тарааж, интернэт орчинд байршуулан сурталчлан ажиллаж байна.

Аймгийн Тогоочдын холбоотой хамтран “Хүүхдийн болон эмчилгээний нарийн боов хийх технологийн танхимийн болон дадлага сургалт”-ыг аймгийн төвд зохион байгуулж, Сүхбаатар, Алтанбулаг сумдын цэцэрлэг, сургуулийн 10 тогооч оролцуулж, хүүхдийн хоолны нэр төрөл, амт чанар, шинэ технологийг эзэмшүүлж, тогооч нарынхаа ур чадварыг ахиулсан арга хэмжээ боллоо.

Сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдсан 862 аж ахуйн нэгж, иргэний мэдээллийг нэгтгэн боловсруулж Дархан-Уул аймаг дахь Монгол банкинд хүргүүллээ.

Засгийн газрын 394 дүгээр тогтоолын 4.6 дахь заалтын дагуу 2018 оны малчдад олгох арьс ширний урамшууллын материалыг программд шивж арьс, ноосны падааныг мал хамгаалах санд хүлээлгэж өгсөн.

Сүхбаатар сумын Хонгор морьт 1-р багт оршин суух С.Алтанхуяг гэх айлд гахай олноор үхсэн сэжиг бүхий өвчний дуудлага 2019 оны 02 сарын 12 өдрийн 11.10 цагт ирсний дагуу шуурхай баг гарч газар дээр нь очиж гахайд үзлэг хийсэн. Үзлэгт нийт 44 толгой гахай байснаас 26 үхсэн гахай, амьд 18 үүнээс шинж тэмдэгтэй 4 гахай байсан. шинжилгээнд дээж авч тухайн өдрийн орой 21 цаг 30 минутанд дээжийг УМЭАЦТЛ-т илгээсэн ба шинжилгээний хариу 02-р сарын 13-ны өдрийн 12 цагийн орчимд ЭЕРЭГ буюу “Гахайн Африк мялзан” өвчин оношлогдсонтой холбогдуулан Сумын Засаг даргын 2019.02.13-ны А/34 тоот захирамжаар тус хорио цээрийн дэглэм тогтоосон. Уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж голомтонд орших Сүхбаатар сумын нийт 22- өрхийн 253 гахайг устгалд оруулж ариутгал халдваргүйжүүлэлтийг стандарт зааврын дагуу хийж гүйцэтгээд байна. Нийт голомт үүссэн 5 сумын 53 өрхийн 932 толгой гахайг устгалд оруулж, 230 өрхийн 71795 м² талбайд ариутгал халдваргүйтгэлийг тусгай тоноглогдсон ДУК автомашинаар хийж гүйцэтгэсэн.

Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар зэрэг сумдаас ирсэн 4 дээжинд нян судлалын шинжилгээг хийж халдваргүй болохыг тогтоож УМЭАЦТЛабораторид баталгаажуулан хариуг зохих газарт хүргүүлэн ажилласан. Сүхбаатар сумын худалдааны төв, нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй МАА-ны гаралтай мах, махан бүтээгдэхүүний Адууны махны 3 дээж 450 кг, Үхрийн махны 13 дээж 1950 кг, Хонины махны 28 дээжны 700 кг, Гахайны махны 1 дээжны 100 кг махны нийт мах махан бүтээгдэхүүний 45 дээжны 3200 кг махны дээж, 120 л сүүний 4 дээжинд АЦ-ийн магадлан шинжилгээ хийж гэрчилгээ олгосон.

Хорио цээрийн дэглэм хэрэгжүүлж буй Орхон, Сант, Цагааннуур, Мандал, Сүхбаатар 5 сумын Орхон, Сант 2 сум хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн, одоогоор 3 сум хорио цээрийн дэглэмд байгаа 5 сумын голомт бүхий голомтын бүсийн нийтийн эзэмшлийн талбай болон 230 өрхийн гахайн байрны 71795 м² талбай

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 01 сарын 30-ны 08 дугаартай тогтоолоор 2019 онд аймгийн хэмжээнд 7801 иргэнд 1022,31 га газрыг өмчлүүлэхээр батлуулав. Үүнээс: одоо эзэмшиж байгаа хашааны газрыг өмчлүүлэхээр- 82,24 га газрыг 690 иргэнд, шинээр 659,78 га газрыг 3355 иргэнд, улсын чанартай авто замын дагуух газарт 280,1 га газрыг 3753 иргэнд, аж

ахуйн зориулалтаар 0,19 га газрыг 3 иргэнд тус тус өмчлүүлэхээр, 2019 оны 01 дүгээр сарын 30-ны 09 дугаартай тогтоолоор барилга, байгууламжийн дэвсгэр газар 5 байршилд 135831 м², гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 37 байршилд 17996,43м², авто машины гаражийн зориулалтаар 51 байршилд 1543 м², эзэмшил газрын зориулалт өөрчлөлт оруулах 2 байршилд 875 м² газрыг тус тус батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Сүхбаатар суманд газар өмчилж авсан 14, Алтанбулаг суманд газар өмчилж авсан 7 иргэнд тус тус газар өмчлөлийн захирамж, кадастрын зураг, хянан баталгааны паспортын хамт тус бүр 3-6 хувь үйлдэн хүлээлгэн өгч улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлж, Захиргааны ерөнхийн хуулийн 43 дугаар зүйлийн 43.2, 43.4-т заасны дагуу захиргааны актыг хүлээн авагч этгээдэд мэдэгдэх, гардуулах ажиллагааг хийж гардан авагч этгээдээр гарын үсэг зуруулан бүртгэл хөтөлж байна.

Газар өмчилж аваагүй тодорхойлолтыг Шаамар суманд 30 иргэнд гаргав.

Лэнд менежер программд 12 сумын хэмжээнд 280 нэгж талбарыг бүртгэж баталгаажуулж ажилласан байна.

Сумдын газрын даамлуудын 2019 оны үр дүнгийн гэрээ байгуулах ажлын хүрээнд тус газраас газрын даамлуудыг чадавхижуулах зорилгын хүрээнд “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх” ажлын үр дүн болон цаашид хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар санал өгсөн.

Сумдын даамлуудтай холбогдож ЛМ-2 программын буруу орсон нэгж талбарт засвар хийх, нэгж талбарт шинээр хаяг олгох, кадастрын өөрчлөлт дуусгах зэрэг ажлыг аймгийн хэмжээнд 17 сумын газрын даамлуудад шаардлагатай байгаа асуудлыг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 тоот тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/170 тоот захирамжийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлын хүрээнд 17 сум 6 тосгодын хураангуй тайланг хүлээн авч мэргэжлийн үнэлгээчний хамт нягтан шалгах ажлыг явуулж байна.

Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа Санхүүгийн хяналт аудитын алба, Баруунбүрэн Эрүүл мэндийн төвийн нийт 7,948,160 төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах, Сэлэнгэ бүсийн сум дундын ой анги, Мандал сумын Засаг даргын тамгын газрын нийт 60,909,090 төгрөгийн үндсэн хөрөнгийг Балансаас балансд шилжүүлэх, Шаамар сумын ИТХ, Эрүүл мэндийн газар, Баруунбүрэн сумын Эрүүл мэндийн төвийн нийт 46,525,000 төгрөгийн үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдаалах тухай тогтоолуудыг аймгийн Засаг даргад танилцуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулан ажиллалаа.

Долоо. Байгаль орчин

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн “2019 онд ахуйн зориулалтаар агнах, барих амьтны тоо, хэмжээ тогтоох тухай” 07 тоот тогтоолоор батлуулан сумдад хүргүүллээ. Сэлэнгэ мөрний ай савд нийт 8000 га талбайд ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил явуулах тендерийн ажлын даалгавар боловсруулж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Цагааннуур, Баруунбүрэн, Ерөө/ Бугант/ зэрэг Ойн сан бүхий сумдуудад ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн 10 жилийн менежментийн хэтийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн санал авч боловсруулан ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын санаачилгаар хэрэгжиж буй Хандлагаа өөрчилье багц ажлын хүрээнд Цагаан сарыг тохиолдуулан “Цэвэрхэн шинэлцгээе” уриан дор Ээж модны ойр орчмын хогийг 2 сарын 25-ний өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв, Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Сүхбаатар, Шаамар сумын байгаль хамгаалагч, Тохижолт үйлчилгээний газартай хамтран цэвэрлэлээ.

Мандал сумын ЗДТГ, Хараа бүсийн сум дундын Ойн ангийн зохион байгуулсан “Ойг хамгаалах, зүй зохистой ашиглах нөхөн сэргээж ажиллацгаая” сэдэвт мод бэлтгэлийн ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдийн зөвлөгөөнийг зохион байгууллаа.

Найм.Сум орон нутгийн талаар

Баянгол сум:

2018 оны ажил үйлсээрээ Хөдөө аж ахуйн салбараас “Түмэн бут” ХХК Улсын аварга тариаланч хамт олон, Монголын радиогоос уламжлал болгон зохион байгуулдаг Таван эрдэнэ нэвтрүүлгийн нэрэмжит “Алтан төлийн эзэн” шагналын Алтан хурганы эзнээр Хараа багийн малчин Н.Отгондорж, Алтан унаганы эзнээр Сэлэнгэ аймагт анх удаа Гонир багийн малчин Ц.Төгсжаргал нар, “Хос түрүү” ХХК аймгийн аварга тариаланч хамт олон, Баян багийн малчин Г.Доржсүрэн “Аймгийн аварга малчин”-аар тус тус шалгарлаа. Мөн сумын хэмжээнд ажил үйлсээрээ 2018 онд тэргүүлэн ажилласан иргэдийн тодорхойлолтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн сумын аварга төрийн албан хаагчаар Баянгол цэцэрлэгийн багш Д.Цэрэндулам, Тэргүүний сурагчаар 12 А ангийн суралцагч Б.Энх-эрдэнэ, “Аварга малчин”-аар Хараа багийн малчин Т.Дандар, Баян багийн малчин Ж.Бат, Хараа багийн малчин Н.Батсүх, Гонир багийн малчин Л.Эрдэнэбаяр нар сумын аварга фермерээр сумын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарын аваргаар Хараа багийн иргэн Ц.Эрдэнэчимэг, сумын аварга тариаланчаар ЗХ-ний 310-р ангийн ХХК-ийн механикжуулагч Г.Эрдэнэбат, сумын аварга ногоочиноор Баян багийн иргэн С.Нарантуяа нар тодорч гахай жилийн босгон дээр шагналаа гардаж авлаа.

ХҮИИ -р жарны “Урвуулагч” хэмээх Шороон гахай жилийн сар шинийн баярыг угтан эмэгтэй 55-аас дээш, эрэгтэй 60-аас дээш насны ахмад настанг суманд үйл ажиллагаа эрхэлдэг 143 аж ахуйн нэгж байгууллагад 539 ахмад настанг хуваарилан хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд сумын 75-аас дээш насны ахмадад сумуу дирдлагууд гарын бэлэг гардууллаа.

Цаг агаар болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан гарах гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд хугацаа алдалгүй мэргэжлийн байгууллагуудад мэдээлэн, яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг бэлэн байлгахад анхаарч сэрэмжлүүлэг, цаг агаарын анхааруулга мэдээг нийтэд мэдээлэн ажилласнаар сумын хэмжээнд онц ноцтой шалтгаан нөхцөл гараагүй хэвийн байсан болно.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 57 тоот тогтоолыг цахим сүлжээгээр сурталчлан, хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллах, өвөл, хаврын улиралд уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосон сумын Засаг даргын албан тоотыг Хүлэг морин спорт уяачдын холбоонд өгч ажиллалаа.

Сумын ахмадын хорооноос зохион байгуулсан “Хаан аав”, “Хатан ээж” шагнал гардуулах ёслолын арга хэмжээний урлагийн тоглолтыг зохион явуулж 150 ахмад оролцлоо. Дархан-Уул аймгийн Хонгор сумын соёлын төвтэй хамтын ажиллагааны дагуу нөхөрсөг спортын 3 төрөлт тэмцээн, урлагийн тоглолт, үдшийн цэнгүүний арга хэмжээг зохион байгуулж 60 иргэн хамрагдлаа.

Соёлын төвөөс санаачлан сар бүрийн 15-нд Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдтэй хамтран “Хамтдаа хөгжье” арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн 2 дугаар сарын 15-нд үйл ажиллагаагаа явууллаа. Арга хэмжээний үеэр караоке тэмцээн, нийтийн бүжгийн уралдаан явуулж, Орон нутаг судлах танхимтай танилцуулан, шинэ номын үзэсгэлэн гарган соёлын төвийн хамт олноос урлагийн тоглолтыг үзүүлж, ХБИ-ийн санаа бодлыг сонслоо. Арга хэмжээг “Бандихүү” ТББ-тай хамтран явууллаа.

ЭМТ-ийн нийт эмч мэргэжилтнүүд 2019 оны 1-р сарын 14-өөс эхлэн уртасгасан цагаар ажиллаж томуу өвчлөлийг бууруулах, хүүхдийг түлэгдэх эрсдлээс сэргийлэх чиглэлээр ард иргэдэд томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээ, мэдээллээр хангах, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулан нийт төвийн болон хөдөөгийн нийт 890 км 176 литр шатахуун, 5,8 литр масло тос зарцуулан 304

өрхийн 603 хүнд үүнээс ахмад настан 79, 0-5 насны хүүхэд 222, жирэмсэн эх 11, 15-49 нас 158, бусад 115 хүнд гэрийн эргэлтээр иргэдэд үйлчилж мэдээ мэдээлэл хүргэж гэрийн орчны үнэлгээ хийж хүүхдийн гар хүрэх газар халуун тогоо, данх халуун сав зэрэг эрсдэлд хүргэж болохуйц зүйлсүүдийг байрлуулахгүй байхыг зөвлөж бага насны хүүхэдтэй айлуудыг зуухаа хашиж хашлага хийх зэрэг зөвлөгөө өгөхөд 5 айл

Булган аймгийн төвд 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр анх гахайн африкийн мялзан өвчин оношлогдсон ба сэрэмжлүүлэг мэдээллийг Сэлэнгэ Аймаг Баянгол Сум, Баруунхараа зарын группүүдэд тавин өдөр тутам гахайтай иргэдтэй утсаар холбогдон малын эмч нар гахайны хашаа хороонд ариутгал хийн ажиллаж байна.

“Баянгол Цаг уурын станц” ХХК, “Майнд-тэч” ХХК, “Анужээ ХХК” зэрэг аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн байнгын ажлын байрны захиалгыг хүлээн авч, ажил хайгч иргэд болон бусад иргэдээ ажлын байрны мэдээллээр хангахын тулд сул чөлөөтэй шинэ ажлын байрны зарыг ажил хайгч иргэдэд утсаар, цахим хаягаар болон биечлэн уулзаж мэдээ мэдээллээр ханган, зөвлөгөө өгч ажилласан.

Тайлант сард шинээр төрсөн 9, шинээр гэр бүл болсон 2, нас барсан 2 тус тус бүртгүүлсэн. Иргэний үнэмлэх шинээр 16 нас хүрч авах 7, 25,45 насны сунгалт хийлгэхээр 5 иргэн иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан. Газрын гэрчилгээ 18, үл хөдлөхийн 3 гэрчилгээг бүртгэлийн дэвтэр хөтлөн олгосон.

Баруунбүрэн сум:

Аймгийн МХГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу 2019 оны 2-р сарын 13-ны өдрийн А/12 тоот Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай захирамжийг гарган сургуулийн ойролцоо үйл ажиллагаа явуулдаг түргэн хоолны газруудыг 3-р сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд үйл ажиллагааг нь түр зогсоосон.

Сумын хэмжээнд том малын хорогдол адуу-4, үхэр-10, хонь-40, ямаа-45 бүгд 99 толгой мал хорогдсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу цэцэрлэгийн хоол, сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх цахим тендер зарласан боловч үнийн санал ирээгүй тул тендер амжилтгүй болсон тул хуулийн дагуу шууд гэрээ байгуулах болоод байна.

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед Сэлэнгэ аймаг Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 01 сарын 11-ны А/02 тоот тушаалын дагуу Ажлын өдрүүд 18⁰⁰-21⁰⁰ хүртэл уртасгасан цагаар ажиллаж, амралтын өдрүүдэд 10⁰⁰-16⁰⁰ цаг хүртэл уртасгасан цагаар ажиллалаа. ЕБС-н ахлах ангийн сурагчдад урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн нийт 95 хүүхэд хамрагдсан. Үзлэгээр ДОХ, Бэлгийн замын шинэжилгээ хийж, 61 охид, 34 хөвгүүдэд үзлэг хийсэн. Мөн 45 сурагчдад “БЗДХ буюу Тэмбүү өвчний тухай” мэдээлэл сургалт сурталчилгаа хийсэн.

Ерөө сум:

“Улсын аварга малчин”-аар шалгарсан Ерөө сумын 2-р багийн малчин С.Түмэн, “Алтан хурга”-ны эзэнээр шалгарсан тус сумын малчин “Ж.Давааням нарын шагнал болон аймаг, сумын аваргуудад шагнал гардуулах арга хэмжээ, сар шинийн баярт зориулсан “Энх мэндийн хадаг” урлагийн тоглолт, шагайн харваа, үндэсний бөхийн барилдааныг тус тус зохион байгууллаа. Хүчит 16 бөхийн барилдаанд сумын заан Э.Эрдэнэ-очир түрүүлж, аймгийн начин Ж.Бат-Оргил үзүүрлэлээ. Мөн сар шинийн баярт зориулсан үзэсгэлэн худалдаанд сүү цагаан идээ, мод модон эдлэл, зөгий бал, хүнсний ногоо, дарж даршилсан бүтээгдэхүүнтэйгээр нийт 7 иргэн оролцсон ба 500,000 төгрөгний борлуулалт хийлээ.

Шайбтай хоккейн өсвөрийн дунд насны УАШТэмцээн 2-р сарын 17-18-ны хооронд Ерөө сумын Бугант тосгоны “Мөсөн гацуур” хоккейн талбай дээр амжилттай болж өнгөрлөө. Тэмцээний нээлтийн арга хэмжээнд Бугант тосгоны Захирагч Д.Эрдэнэбулган, МХХ-ны дэд Ерөнхийлөгч С.Батсүх, МХХ-ны НБДарга н.Батэрдэнэ,

Шигшээ багийн ахлах дасгалжуулагч н.Мэргэн, Сэлэнгэ аймгийн БТСГ-н дарга н.Батмөнх, Ерөө сумын Засаг дарга М.Ганбаатар, Засаг даргын орлогч Э.Одгарав, Канад улсын элчин сайдын төлөөлөгч, Канад улсын дасгалжуулагчдын баг хүрэлцэн ирж оролцлоо. Тэмцээнд 4 багийн 60 гаруй өсвөрийн тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж оролцсоноос Б.Алдармөнх дасгалжуулагчтай, Э.Амартөр ахлагчтай Бугант баг түрүүлж аваргын алтан медаль, шилжин явах цомын эзэд болцгоолоо. 2-р байрыг Улаанбаатар хотын Ананд-эрдэнэ баг, 3-р байрыг Дархан уул аймгийн Шарын гол сумын Золбоот тамирчид баг тус тус эзэллээ.

Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтанд 2 сарын байдлаар 2275 хамрагдах төлөвлөгөөтэйгээс томуу томуу төст амьсгалын замын халдварт өвчний дэгдэлт их байсан учраас гүйцэтгэл 1605 буюу 71 хувь нь хамрагдсан байна. Томуу томуу төст өвчлөл их байгаатай холбогдуулан БСШУС-ын сайдын А/31-р тушаал, БСУГ-ын газрын №26 дугаар албан бичгийн дагуу өмчийн бүх сургууль цэцэрлэгүүдийг 2019.01.21-нээс 2019.02.11-ний өдрийг хүртэл үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон. “Монгол үндэсний хоол” өдөрлөг, ахлах бүлэг “Монгол ёс”, Дунд бүлэг “Хүнсний дэлгүүр”, Бага бүлэг “Монгол дээл” сэдвийн хүрээнд нийт 624 цагийн үйл ажиллагааг явуулж, цэцэрлэгийн үндсэн сургалтанд хамрагдаагүй малчдын 40 гаруй өрхийн хүүхдүүдэд зайны сургалт болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Эрүүл мэндийн төв нь 2 сарын байдлаар амбулаториор 361 хүнд үзлэг хийснээс. Стационариор 25 хүн хэвтүүлэн 263 ор хоног ашигласан. Сумын эмнэлэгт төрсөн эх -1, нярай -1, Жирэмсний хяналтанд 42 эх хяналтанд байгаа бөгөөд 2 сард шинээр 5 эхийг хяналтанд авлаа.

Нийтийн төвлөрсөн хогийн цэгийн ойр орчимд хийссэн гялгар уут, ундааны сав, нимгэн нийлэг хальсан уутнуудыг цэвэрлэх ажлыг 1, 2-р багийн 130 иргэн, ЕБС, Нарлаг цэцэрлэг, ЗДТГ-ын хамт олон нийлсэн 40 гаруй албан хаагч нар цэвэрлэлээ. Цэвэрлэх ажилд нийт 9 ачааны автомашин оролцож 23 тэвш хогийг цуглуулан асгаж шатаалаа.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн ХХААГазраас газар тариалангийн аж ахуй нэгжүүдээс ургамал хамгааллын бодисын захиалга, 2019 онд тариалах талбайн хэмжээ үрийн судалгаа ирүүлэх тухай албан тоотын дагуу тус сумын 13 аж ахуй нэгж, 4 иргэнээс дээрх захиалгуудыг авч нэгтгэн хүргүүлсэн. Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газраас аж ахуй нэгжүүдээс нөөцөлсөн үрийн дээж авч шинэжилгээнд хамруулах тухай албан бичгийн дагуу Ерөө суманд үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуй нэгж 1 иргэнээс нийт 12кг үрийг хүргүүлж ажиллалаа.

Монгол улсад газар тариалангийн салбар бие даан хөгжсний түүхт 60 жилийн ойг угтсан ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулсан 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажил хийгдэж байна.

Зүүнбүрэн сум:

Атрын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг, салбар баг, ажлын төлөвлөгөөний төслийг гарган ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг зохион байгуулаа.

Монгол Улсад анх удаа гарсан африкийн гахайн мялзан өвчин оношлогдсонтой холбогдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2019 оны 1-р сарын 22-ны өдрийн сумын Онцгой комиссын 01 тоот тушаалаар, ажлын хэсэг томилогдон, мал эмнэлгийн холбогдох мэргэжилтнийг оролцуулан ажиллалаа. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 117450 төгрөгний зардал гаргаснаар мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 удаа зохион байгуулж 830 м2 талбайг хамрууллаа. Сумын хэмжээнд гахайн аж ахуй эрхэлдэг 1 аж ахуй нэгж, 33 өрхийн 193 гахайн судалгааг баг тус бүрээр гаргаж холбогдох утасны дугаар, эзний овог нэрийн хамт гаргаж холбогдох байгууллагад хүргүүллээ. Дээрх гахайн халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх ажлыг Жаргалант 1-р баг, Бэлчир 2 дугаар багийн гахайн аж ахуй эрхлэгч дээрх өрхүүдэд зохион байгуулж, гахайн аж ахуй эрхлэгч 44 өрхийн, 60 гаруй иргэнийг хамруулж, гахайг

хашаанаас гаргахгүй байх, бусдын гахайтай нийлүүлэхгүй байх, тодорхой хугацаанд байнгын хариулга, маллагаанд байлгах, гахай маллаж буй хашаа, хороо зэрэгт шаардлагагүй бол гаднаас хүн, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхгүй байх талаар сэрэмжлүүлэг зөвлөмж, ажиллалаа.

Ургамал хамгааллын бодис, бордоо, үрийн захиалгыг иргэн, аж ахуйн нэгжээр, хөдөө аж ахуйд ашиглагдаж буй техникийн судалгааг гаргаж холбогдох дээд газарт хүргүүлсэн бөгөөд 2019 онд 11794 га талбайд улаан буудай, 200 га талбайд рапс, тэжээлийн ургамал 400 га нийт 12394 га талбайд тариалалт хийх төлөвлөгөөтэй байна.

XVII жарны "Тийн Урвуулагч" хэмээх Шороон гахай жилийн сар шинийн босгон дээр улс, бүс, аймгийн уралдаанд уясан морио амжилттай хурдлуулж, Монгол үндэсний өв соёл болсон морь уях, эдлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх үйл хэрэгт шамдан зүтгэж Сэлэнгэ аймгийн "Алдарт уяач" цолоор шагнагдсан Д.Ганзориг, Д.Болдхүү, аймгийн Сайн малчнаар шалгарсан Б.Натар, О.Хөхөө, Сумын сайн малчнаар шалгарсан малчин Ч.Бямбацог, сумын Алдарт уяачаар шалгарсан Г.Самбуу, уралдаанч хүүхдээр шалгарсан Х.Батялалт, Шилдэг фермерээр шалгарсан Б.Баярмагнай, Шилдэг сурын харваачаар шалгарсан иргэн Г.Бүрэнжаргал, Шилдэг шагай харваачаар шалгарсан иргэн М.Олонбаяр нарын шагналыг гардуулж, ажил хөдөлмөрөөрөө тэргүүлсэн иргэдийг аймаг, сумын Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагналаа.

Дэлхийн банкны санхүүжилтээр "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 1-5- дугаар ангийн номын санд 6,192,480 төгрөгний 765 ширэхг номыг аймгийн БСУГ-аас хүлээн авч анги тус бүрээр коджуулан эцэг эх, сурагчдад танилцуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн 32 сурагчдад "Санхүүгийн боловсрол" аяны хүрээнд "Мөнгө, түүний хэрэглээ" сэдэвт 2 дугаар шатны сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж, Томуу, томуу төст өвчин, артерийн даралт, чихрийн шижин, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 17 эмч, эмнэлгийн албан хаагчид, 19 хэвтэн эмчлүүлэгчдийг хамруулан зохион байгууллаа.

Сургуулийн хэмжээнд хэрэглэж буй ариутгалын бодисын хэрэглээнд хяналт тавин ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийгдэж байна.

Сумын Эрүүл мэндийн төв 19 иргэнийг хэвтүүлэн эмчилж, амбулатороор 228 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 144, урьдчилан сэргийлэх үзлэгээр 26, диспансерийн хяналтаар 32, гэрийн идэвхтэй эргэлтээр 8, дуудлагаар 18 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлээ.

Жавхлант сум:

Сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, төрийн албаны өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлого зорилтын талаар санал солилцож, албан байгууллагын дарга, эрхлэгч нар төрөөс баримталж буй боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн талаарх мэдээллийг хийж, уриалга гаргалаа.

Мөн тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 4 удаа болж, цаг үеийн ажил арга хэмжээнүүдийг хэлэлцлээ.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг олгох ажлыг зохион байгуулж, төрсний бүртгэл -2, шилжилт хөдөлгөөн-4, иргэний үнэмлэх олголт-5, гэрлэлтийн бүртгэл-1, шинээр иргэний үнэмлэх -1, сунгалт -3 иргэн тус тус нийт 16 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Тухайн сард нийт 570 үзлэг хийж, дархлаажуулалтанд товллын дагуу 31 хүүхдийг хамруулан эхэд нь ДДУХ-ийн талаар зөвлөгөө өгч, жирэмсэний давтан хяналтанд байгаа 23 эхийг үзэж, шинээр хяналтанд авсан 4 эхийг жирэмсэний хяналтанд нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэг шинжилгээнд хамруулах арга хэмжээ авлаа. Хөдөөгийн 1, 2-р багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж 0-5 насны 67 хүүхдийг жинлэж, жирэмсэн болон өндөр настай иргэдийг хянаж зөвлөгөө

өгөхөөс гадна, чихрийн шижин, артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт анх удаа 54 иргэнийг, давтан үзлэгт 206 иргэнийг хамруулж тухайн онд хамрагдвал зохих иргэдийг 100% хамруулаад байна. Мөн 15-60 насны 220 иргэнээс цусны шинжилгээг авч өөрчлөлттэй илэрсэн 5 иргэнийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгууллаа.

“Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд аймгийн төв болон сумын бүх сургуулийн бага ангийн бүлэг бүрийн ангийн номын санд зориулан хүүхдийн номын каталог боловсруулан, Боловсролын салбарын мэдээллийн системээр дамжуулан сургуулиуд онлайнаар номын захиалга хийсний дагуу номыг сургуулийн 1-5 анги тус бүрт нийт 4 363 220 төгрөгийн үнэ бүхий 400 ширхэг номын сангийн номыг хүлээлгэн өглөө.

Жил бүр уламжлал болгон зохиогддог “Дээлтэй Монгол” нэг өдрийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулж, өдөрлөгийн үеэр багш, эцэг эх, хүүхдүүдийн дунд «Дөрвөн бэрх» тэмцээн “Адуучин баг” тэргүүн байр, “Ямаачин баг” дэд байранд шалгарсан.

Тус сумын хэмжээнд 2019 онд улаан буудай 9405 га талбайд тариалах төлөвлөгөөтэй байна. Хаврын тариалалтанд 1316 тн үр шаардлагатай бөгөөд өөрсдийн нөөцөлсөн үр 334 тн байгшаа бөшөөп тооцоогоор 982 тн үр дутагдах төлөвлөгөөтэй байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд хур тунадас бага орж хаврын хуурайшилт ихтэй байгаа тул сумын нийт иргэдэд Төрийн мэдээлэлийн самбар болон сумын цахим сүлжээгээр дамжуулан ойгоор аялж зугаалах үедээ асаасан гал татсан тамхины иш, шүдэнз болон үнс нурмаа бүрэн унтрааж байх талаар анхааруулга, сэрэмжлүүлгийг нийт 56 иргэдэд хүргэж ажиллалаа.

Мөн хаврын урь орж голын мөсний зузаан нимгэрч цөмрөх эрсдэл ихтэй байгаа тул голын мөсөн дээгүүр зорчихгүй байж өөрсдийн амь нас, эд хөрөнгөө хамгаалахийг анхааруулж, сэрэмжлүүлгийг хүргээд байна.

Мандал сум:

Сумын Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2-р сарын 19-ны өдөр зохион байгуулж, 2019 онд сумын төсвийн ерөнхийлөн захирагч нийт 22 төсвийн шууд захирагч болон 9 багийн засаг даргатай үр дүнгийн гэрээ байгууллаа. Зөвлөгөөнөөр Сумын төсөв санхүү, гэмт хэрэг, эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, 2019 оны эдийн засаг нийгмийн үзүүлэлт, Зорилтод өрхийн хөгжил хамгаалал сэдвээр төсвийн шууд захирагч нарт мэдээлэл хийн төсвийн байгууллагын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн талаар танилцууллаа.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Gyeongshangnamdochangnyong county сумын албаны хүмүүс болон Аз жаргал бэлэглэе нийгэмлэгийн төлөөлөл сумын Засаг даргын урилгаар тус суманд айлчилж, нийгмийн салбарт тодорхой ажлуудыг зохион байгуулахаар боллоо.

Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор JCI Монгол байгууллагын хөгжлийн зөвлөлтэй хамтран "Ярих ур чадвар ба манлайлал", "Найз нөхөрлөлийн сүлжээ үүсгэх" сэдэвт сургалтыг хийж, 75 төрийн албан хаагч хамрагдлаа.

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл тайлант сард 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настан шинээр-3, сунгалт-6, хөгжлийн бэрхшээлтэй иргэн сунгалт-5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдшинээр-1, сунгалт-4, тэжээгчийн тэтгэвэр сунгалт-1, нийт 20 иргэний өргөдлийг шийдвэрлэлээ.

ЕБ-ын 1-р сургуулийн 9-р ангийн сурагчдаас санаачлан зорилтот өрхийн 4 өрхөд хүнсний бүтээгдэхүүн, гэр ахуйн хэрэгслээр тусламж үзүүллээ.

Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил хайгчаар бүртгүүлсэн 22 иргэнийг Lmis программд бүртгэн баталгаажуулж, 6 иргэнийг ажилд зуучилсан

Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах болон хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлэх журам, тээврийн хэрэгсэл түр хадгалах байрны ажиллах журмуудын нээлттэй

хэлэлцүүлгийг 2019.01.09-ны өдөр ерөнхий боловсролын 3 болон 4-р сургуулийн 91 албан хаагчдын дунд, 2019.01.11-ны өдөр Хэрх 4-р багийн 84 иргэдийн дунд, 2019.01.15-ны өдөр ерөнхий боловсролын 1 болон 2-р сургуулийн 92 албан хаагчдын дунд, 2019.01.17-ны өдөр Минжийнхангайн 7-р багийн 153 иргэдийн дунд нийт 5 удаа 420 иргэнийг хамруулан зохион байгуулж, холбогдох судалгаа тооцоог бэлтгэн журамд иргэдийн саналыг тусгалаа.

Суманд мөрдөгдөх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах болон хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлэх журмыг боловсрууланиргэдээр хэлэлцүүлсэний дараа сумын ИТХ-аар хэлэлцүүлж, ИТХ-ын 2019.01.30-ны өдрийн 74 тоот тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхэллээ.

Мөн Тээврийн хэрэгсэл түр хадгалах байрны ажиллах журмыг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж 2019.01.30-ны өдрийн 73 тоот тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхэллээ. Тээврийн хэрэгслийн хоногийн төлбөрийн хэмжээг шинэчиллээ.

Шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн ажлыг хийж гүйцэтгэж буй “Электрик ком” ХХК-ны ажлын гүйцэтгэлтэй танилцаж, холбогдох зөрчлүүдийг илрүүлэн Сэлэнгэ аймгийн мэргэжлийн хяналтын газарт хандаж барилга техникийн улсын байцаагч, эрчим хүчний улсын байцаагч нарыг орон нутагтаа ажиллуулсаны дагуу холбогдох байцаагчид тус гүйцэтгэгч байгууллагад холбогдох зөрчлийн хэрэг үүсгэн зөрчил хянан шалгах ажиллагааг эхлүүлээд байна.

Орхон сум:

Орхон сумын түүхт 60 жилийн ой 2019 онд тохиож байгаатай холбогдуулан Сэлэнгэ аймаг, Дархан-Уул аймагт ажиллаж амьдарч байгаа Орхон сумын иргэдийн уулзалт, сар шинийн золголтыг 2-р сарын 16-ны өдөр Дархан уул аймагт зохион байгууллаа. Уулзалтын үеэр сумын 60 жилийн ойн арга хэмжээнд зориулан иргэн аж ахуйн нэгжүүд хандив өгч сумын “Ахмадын золбоо” хамтлаг, сумын соёлын төвийн албан хаагчид ая дуу өргөлөө. Мөн түүхт ойн арга хэмжээний хүрээнд “Угтал цэнгүүн Орхон нутаг-60” урлагийн тоглолтыг Улаанбаатар хотод 2-р сарын 23-нд зохион байгууллаа.

Энэ сарын 17-ны өдөр УИХ-ын гишүүн Дондогдоржийн Эрдэнэбат тус суманд ажиллаж ард иргэдтэй уулзалт зохион байгуулж 2018 оны ажлаа тайлагнаж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авлаа.

Иргэд олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх үүднээс Сэлэнгэ аймаг Орхон сум сумын цахим хаяг болон Orkhon Sum ZdtgSelenge Facebook хаягаар цаг үеийн мэдээ мэдээллүүдийг хүргэн ажиллаж байна. Тайлант сард мал амьтаны эрүүл мэндийн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулийн сургалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай хууль, газрын тухай хууль, нийгмийн халамж үйлчилгээний тухай хууль зэрэг хуулиудаар иргэдэд мэдээ мэдээлэл өгч давхардсан тоогоор 326 иргэнийг хамруулсан байна.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгож ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохоор нийт 148 өрхөөс 283 санал авч сумын ИТХ-ын 9-р хуралдаанаар тэргүүлэх чиглэлийн саналыг оруулан батлуулж, 2019 онд тариалах талбайн судалгаа, үр бордоо, уриншийн захиалгыг аж ахуйн нэгж, иргэдээс авч ХХААГ-т хүргүүлэн ажилласан.

Тайлант сард 48 иргэнд 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын холбогдох хууль тогтоомжийг сурталчилан таниулж, 9 иргэний улсын бүртгэлийн хэлтэсрүү улсын бүртгэлийн гэрчилгээ авах материалтай нь явуулсан.

2019-2020 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн суралцах сурагчдын судалгааг гаргалаа. Боловсролын чанарын шинэчлэл төслөөс нийлүүлсэн ангийн номын сангийн номуудыг ангиудад нь хуваарилан өгч, хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өглөө. БСУГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу 1-11-р ангийн сурагчдаас “Сэтгэх чадвар”-ын олимпиадыг авч, цаашид хэрхэн ажиллах талаар багш нартай санал бодлоо

солилцож, хийх ажлаа төлөвлөгөөндөө тусгалаа. Багш нарын хөтөлбөл зохих бичиг баримтад хяналт шалгалт хийж, зөвлөгөө өглөө. II-V ангийн STEM сургалтын цагаар сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор нийт 6 цагийн хичээлийг зохион байгуулан сурагчдын

ДЗОУБ-ын Сэлэнгэ орон нутаг хөгжүүлэх хөтөлбөрийн зохицуулагч Ж.Мөнхзул тус сургуулийн СӨУБ-ын сурагчдыг чадавхжуулах сургалтыг нийт 18 сурагчдад зохион байгуулсан. Тус сургалтаар сурагчдын манлайлал, оролцоо, клубын үйл ажиллагааг хэрхэн тогтвортой зохион байгуулах талаар сурагчдад зөвлөгөө өгч, “Гайхамшигт үр хөврөл” сургалтыг IX-XI ангийн сурагчдад зохион байгуулж, үр хөндөлтөөс үүсэх эрсдлийн талаар сурагчдад мэдээлэл хүргэлээ.

Орхон 12-р цэцэрлэг нь 2019 оны 02-р сард нийт 420 хүүхдийг СӨБ-д хамруулан ажиллалаа. Улс нийтээрээ ханиад, томууны дэгдэлт ихтэй байгаатай холбогдуулан дээд шатны байгууллагаас ирсэн захирамжийн дагуу 1-р сарын 18-наас 02-р сарын 11-нийг хүртэл хүүхэд хүлээн аваагүй. Энэ хугацаанд багш, ажилчид ажлын цагийн хуваарийн дагуу ажлаа гүйцэтгэсэн бөгөөд “ Бид хүүхдүүдтэйгээ хамтдаа ” уриан дор долоо хоног бүр өвчлөлийн судалгааг гарган хүүхдүүдийн өвчлөлийн байдалд хяналт тавин ажиллаж, гэрээр эргэлт хийн, гарын авлага тараан ажилласан. Эргэлтийн судалгаагаар цэцэрлэгт хамрагдаж байсан 92 хүүхдээс 65 хүүхэд өвчлөлгүй эрүүл, 7 хүүхэд өвчтэй, гэрээр эмчлүүлж байгаа, 10 хүүхэд хөдөө өвөө, эмээгийхрүүгээ явсан, 10 хүүхэд харах хүн байхгүй учираас орон нутгаас гарсан байсан.

XVII жарны урвуулагч хэмээх шороон гахай жилийн сар шинийн баярт зориулсан “Өв соёл” тэмцээнийг амжилттай зохион байгуулан төр төсвийн байгууллагууд болон ард иргэдийн хамтарсан 6 баг оролцож ЕБС-ын “Эрдмийн элч” баг тэргүүн байранд шалгарч хундан цагаан хонь, ЗДТГ-ын “Цагаан сар ” баг дэд байранд шалгарч сахалтай хониор тус тус шагнууллаа.

Орхонтуул сүм:

2019 оныг сумын хэмжээнд “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх жил” болгон ажиллах зорилт тавьж, 2-р сарын 17-ны өдөр төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд 11 байгууллагын нийт 120 гаруй төрийн албан хаагч хамрагдсан байна. Төрийн албан хаагчдын нэгдсэн хоёрдугаар зөвлөгөөнийг угтан Гар бөмбөгийн тэмцээн, цасны баярын арга хэмжээг зохион байгуулж шалгарсан байгууллага хамт олныг шагнаж урамшуулж, төрийн захиргааны албан хаагчидтай 2019 оны жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэрээг байгууллаа.

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж сумын Сайн малчин алдарт уяач шалгаруулах тухай болон Төрийн албан хаагчдын нэгдсэн хоёрдугаар зөвлөгөөн зохион байгуулах тухай, иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлт зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Мөн Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдийн анхдугаар зөвлөгөөнөөс гарсан санал санаачилгыг ажил хэрэг болгож төр, төсвийн байгууллагын ажилчдын цалингаасаа бий болгосон хуримтлалыг журмын дагуу зарцуулж 6 төрийн албан хаагчид мөнгөн тусламжийг төр, төсвийн байгууллагын дарга эрхлэгч нар болон нийгмийн ажилтнууд гардуулан өгсөн байна.

Энэ сард шинэ төрөлт-5, нас баралт-2, гэрлэлт-3бүртгэгдсэн байна. Шилжиж ирсэн-11 иргэнийн бүртгэлийг хийж ажилласан байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд “Шинэ төрсөн эх, хүүхдэд хүндэтгэл үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган 5 эх, хүүхдэд Засаг даргын гарын бэлэг, Дурсамж гардуулан өгсөн байна.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг олгож, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж 1 хүнд-84.3 мян\төг оршуулгын тэтгэмж 1 хүнд-1000.0 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 2 хүнд 1655.3 мян\төг ажилгүйдлийн тэтгэмжинд

1 хүнд 372.6мян\төгрөгийг хуваарийн дагуу харилцагч банкуудаар дамжуулан олголоо.

Гоц халдварт гахайн африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын хэмжээнд гахай тэжээдэг өрхийн тоог нарийвчлан гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ. Сумын Онцгой комисс 2019.01.15-ны өдөр хуралдаж урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах Ажлын хэсэг томилон ажиллуулах шийдвэр гаргаж сумын Засаг даргын 2019.01.16-ны өдрийн А\05 тоот захирамжаар сумын ЗДТГ-н даргаар ахлуулсан ажлын хэсэг томилон ажиллалаа. Захирамжаар ажлын хэсгийн ажиллах цагийн хуваарь, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, холбогдох газарт мэдээ хүргүүлэх хуваарь зэргийг батлан сумын хэмжээнд 28 өрхөд 358 гахайд үзлэг тандалт хийж өдөр бүр 16 цагт Сайхан сум дахь Гал унтраах, аврах 61-р ангид мэдээ өгч ажиллалаа.

Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдийн улаан буудай, улаан буудайн үрийн захиалга, бодисын захиалга, тоног төхөөрөмжийн судалгааг хийж гаргаж холбогдох газарт нь хүргүүллээ.

Аймаг, сумын Сайн малчин, Алдарт уяачдын материалыг бүрдүүлэн дээд шатны байгууллагуудад хүргүүлснээр Улсын аварга малчнаар Баянцогт 2-р багийн малчин Х.Батсүх, “Алтан төлийн эзэн”-ээр Шар-Ус 1-р багийн иргэн О.Батбаяр нар шалгарлаа. Аймгийн аварга механикжуулагчаар Баянцогт 2-р багийн иргэн “Гангранд”ХХК-ний тракторчин Л.Оюунэрдэнэ, “Аймгийн аварга фермер”-ээр Рашаант тосгоны иргэн Б.Чинтөгс нар шалгарсан бол Сумын “Сайн малчин”-аар Баянцогт 2-р багийн малчин Л.Ганзориг, Хонгор-Овоо 3-р багийн малчин Ж.Чимэдэцэрэн, сумын шилдэг фермерээр Шар-Ус 1-р баг, Рашаант тосгоны иргэн Л.Батдорж, сумын “Алдарт уяач”-аар Шар-Ус 1-р баг, Рашаант тосгоны иргэн Л.Энхбат, 2-р багийн иргэн Б.Тэмүүжин нар шалгарч хөдөлмөрөө үнэлүүллээ.

Хүүхэд багачуудыг үндэсний түүх соёлоо дээдлэх бахархан дуухайх хойч үедээ өвлүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Монгол бахархал” өдөрлөгийг 24-р цэцэрлэг, ЕБ2-р сургууль зохион байгуулсан байна.

Сурагчдыг томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх сурагчдыг амны хаалт зүүлгэх, цэгэн массаж хийж сурах зэрэг ажлыг жигдрүүлж, ханиад томуунаас урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийн ажлуудыг зохион байгууллаа.

2-р сарын 25-ны байдлаар нийт үзлэг-216, амбулаторийн үзлэг -75, урьдчилан сэргийлэх үзлэг-92, гэрийн эргэлт-28, гэрийн хяналт-21 нийт дуудлага 18 ирсэнээс алсын дуудлага-6, ойрын дуудлага-12 байна. 2-р сард нийт 19 хүүхдэд товлолын дагуу вакцинд хамрагдсан, 75 хүүхдийн жин өндрийг хэмжиж гэрийн эргэлт хийсэн байна. Өнөөдрийн байдлаар 19 жирэмсэн эх хяналтанд байна. Умайн хүзүүний өмөн, хөхний өмөнгийн хавдар илрүүлэх шинжилгээнд 3 хүн хамрагдсан байна.

Сант сүм:

2019 онд тариалах талбай, бэлтгэх уринш, дутагдах үр, бордоо, ургамал хамгааллын бодисын захиалгыг аж ахуйн нэгж иргэдээс авч 4323.4 га талбайд үр тариа, 2435.7 га талбайд уринш, 390.8 тн дутагдах үр, нийлмэл бордоо 265.7 тн, азотын бордоо 78.3 тн, органик бордоо 783.4 тн, гумат 370 тн, үр ариутгах бодис 310.4 тн, алмазис 32.4 л, Феназин 786.3 л, Зингер 16 кг, Пумасупер 2334.4 л, Раундап 15821.9 л тус тус захиалсан байна.

Мал төллөлт төл бойжуулалтын явцын мэдээг 7 хоног бүр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт гарган өгч байна. Сумын хэмжээнд үнээ 28, эм хонь 560, эм ямаа 210 бүгд 798 толгой мал төллөн төлийн хорогдолгүй бүрэн бойжиж байна.

Сумын хэмжээнд гахайн африкийн мялзан өвчин гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоож авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 23 зүйл заалттайгаар боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Гамшгаас хамгаалах штабын ажлын мэдээг аймагт өдөр бүр тогтмол мэдээлж ажилласан ба хорио цээрийн үед авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд тээвэр шатахууны зардал

462,3 мянган төгрөг, хүнс хоолны зардал 252,5 мянган төгрөг, ариутгал материалын зардал 61,1 мянган төгрөг, шуудан холбооны зардал 25,0 мянган төгрөг, нийт 800,9 мянган төгрөгийг Засаг даргын нөөцөөс зарцуулагдсан.

Сумын хэмжээнд өвчний шинж тэмдэг дахин илрээгүй тул 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хязгаарлалтын дэглэмд шилжүүлж сумын Засаг даргын 02 дугаар сарын 25-ны өдрийн А/18 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг цуцласан байна.

Сумын ИТХ-ын 2019 оны 05 тоот тогтоолоор 2019 онд бэлтгэх модны хэмээг Сант сум 3480м.куб түлээ, 750м.куб хэрэглээний мод, Орхон сум 800м.куб түлээ бэлтгэхээр батласан байна.

Сумын хэмжээнд 02 дугаар сарын 10-наас эхлэн золбин нохой устгалын ажил эхлэж 36 нохой устгаад байна.

Хулгайн антай холбоотой иргэний мэдээллийн дагуу ойн эргүүл, хууль бус ангийн эргүүл хяналтын ажлыг сумын 1-р багийн хөдөөгийн чиглэлд зохион байгуулж төсвөөс 30 л шатахуун зарцуулагдсан байна.

FAO төслийн хөрөнгө оруулалтаар нөхөрлөлүүдийн ойн менежментийн төлөвлөгөөг олон жилийн давтамжтайгаар боловсруулахад нөхөрлөлийн гишүүдийн оролцоог хангах сургалт хэлэлцүүлэгт Хан Хушаат, Ноёны бууц нөхөрлөлийн 26 гишүүн хамрагдсан байна.

"Адра Монгол" Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй "ОРГАНИК ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮНШЛЭЛ" төсөлд хамрагдсан Эсэргэнэ хоршооноос "Байгаль орчинд ээлтэй ОРГАНИК ГАЗАР ТАРИАЛАН -ийн ач холбогдол хөгжүүлэх боломж" сэдвээр сургалт мэдээллийн ажил зохион байгуулж 20 гаруй ногоочид хамрагдсан байна.

"Органик хөдөө аж ахуйн түншлэл" төслийн хүрээнд Дархан –Уул аймагт зохион байгуулагдсан "Органик бордоо хэрэглэхийн ач тус" сэдэвт сургалтад сумаас 30 гаруй ногоочид хамрагдсан байна.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олголоо.

Соёлын төвөөс зохион байгуулж буй "Бүжигчин хамт олон" байгууллага сурталчлах аяны хүрээнд "Бүгдээрээ бүжиглэж сурцгаая" цэнгүүн арга хэмжээнд ЗДТГ-ын хамт олон бүрэн бүрэлдэхүүнээр оролцож "16 тоот" чөлөөт бүжиг, 3 тамирын уянга, Жаахан Дулмаа, Хүмүүн төрөлхтөн бүжгийг сурч оролцон 140 гаруй иргэн үзэж сонирхсон байна.

Монгол ёс заншлаа сэргээх, үр хойчдоо өвлүүлэн уламжлуулах зорилгоор "Үл мартагдах үнэт өв соёл мину" арга хэмжээг ЕБС-ийн 6-7-р ангийн сурагчдын дунд зохион байгуулж 4 баг оролцож 50 гаруй үзэгчдэд монгол ёс заншлаа сурталчилсан байна.

Олон Улсын эх хэлний өдөрт зориулж Монгол хэлний тухай хуулийг сурталчилсан гарын авлага, материалыг ЗДТГ-ын цахим хаяг, Соёлын төв, номын сангийн мэдээллийн самбарт байршуулсан байна. ЕБС-ийн 7-11-р ангийн сурагчдын дунд "Үндэсний бичгээрээ зөв уншиж бичигчгээ" цэвэр зөв бичгийн уралдааныг зохион байгуулж 69 сурагч хамрагдсан байна. Мөн монгол бичгээр зөв унших чадварын уралдаан зохион байгуулагдаж 16 сурагч оролцлоо. Монгол бичгээр хэвлэгдсэн 26 ширхэг ном, Хүмүүн бичиг сонингоор үзэсгэлэн гаргалаа.

Сайхан сүм:

Сумын Засаг дарга 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2016-2018 оны хэрэгжилтийн тайланг иргэддээ танилцууллаа. Үйл ажиллагааны хүрээнд сумын Засаг дарга О.Буянаа сумын хэмжээнд үйл ажиллагааны хөтөлбөр хэрхэн хэрэгжсэн талаарх товч мэдээллийг танилцуулж, сумын ААНБ-ын дарга, эрхлэгч нар Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг салбар салбартаа хэрэгжүүлэн ажилласан талаарх тайлант танилцуулгыг иргэдэд хүргэлээ.

Мөн хурлын үеэр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд сум орон нутагт хийгдэх бүтээн байгуулалтын ажлын саналыг иргэдээс авсан байна. Ийнхүү иргэдийн оролцоотой засаглалыг хөгжүүлэхэд иргэд олон нийтийн санал санаачлага хамгаас чухал болохыг хөндсөн энэ удаагийн тайлант хурлыг Хөтөл Соёлын ордны уран бүтээлчдийн урлагийн тоглолт хийлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат 2-р сарын 20-нд тойрогтоо ажиллаж Хөтөл хот, Номгон тосгоны иргэдтэй уулзалт хийсэн.

Уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан сумын хэмжээнд 85-аас дээш 22, харьяалалгүй 70-84 насны 124 ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулсан. Урвуулагч хэмээх шороон гахай жилийн сар шинийн баярыг угтан Сэлэнгэ аймгийн “Миний монгол” телевизтэй хамтран “Бахархах түүхтэй Сайханчууд” сар шинийн баярын нэвтрүүлгийн зураг авалт Соёлын ордны бүжгийн зааланд зохион байгуулан ажиллаж, сумын аж ахуйн нэгж байгууллагын удирдлагуудыг иргэддээ сар шинийн мэндчилгээ дэвшүүлсэн.

Сайхан сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нэгж нь 2-р сарын тайлангийн хугацаанд нийт 110 мэдүүлэг хүлээн авч, Монгол Улсын үндсэн хууль, Иргэний тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад эрх зүйн актууд болон дээд шатны байгууллагын чиглэл заавар зөвлөмжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 56 мэдүүлэг хүлээн авч хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. 2019 оны 02-р сарын байдлаар 13 хүү, 12 охин төрснийг холбогдох бичиг баримтыг үндэслэн регистрийн дугаар, төрсний гэрчилгээ олгон, Улсын бүртгэл мэдээллийн цахим санд бүртгүүлээ. Гэрлэлтийн бүртгэл 4, гэрлэлт цуцалсны бүртгэл 4 бүртгэгдсэн бол нас барсны бүртгэл 4 тус тус бүртгэгдсэн байна.

Шилжин ирсэн 35, шилжин явсан 0 иргэний бүртгэлийг журмын дагуу хөтөлж, Улсын бүртгэл мэдээллийн санд тусгууллаа. Иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл буюу / хурууны хээ /-д нийт 28 иргэн хамрагдсанаас 16 насанд хүрч шинээр захиалж байгаа 6 иргэн, 25 болон 45 насны сунгалтыг 2 иргэн тус тус бүртгэсэн байна.

2019 онд тариалах үр тариа, төмс хүнсний ногооны үрийг лабораторийн шинжилгээнд хамруулахаар аймгийн МХГ-т хүргүүлж, аж ахуйн нэгж, иргэний үр, бордоо, хор гербицидийн судалгааг нэгтгэн холбогдох газарт хүргүүлж, атарчдын судалгаа болон усалгаатай талбай, техник хэрэгслийн судалгааг гаргаад байна.

Сумын хэмжээнд 2 сарын байдлаар нийт 4079 хээлтэгч мал төллөсөн буюу үүнээс гүү 52, үнээ 256, эм хонь 2204, эм ямаа 1567 төллөсөн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019.02.13-ны өдрийн 1/113 тоот хугацаатай албан бичгийн дагуу Африкийн гахайн мялзан өвчин гарсантай холбогдуулан суманд зохион байгуулсан ажил үйлчилгээний бичмэл тайланг холбогдох газарт хүргүүлж, хяналт тавин ажиллалаа.

Ойн болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шалгалтыг хийж, хуулийн этгээд 3, иргэн 26 хамрагдсан ба хяналт шалгалтын явцад нийт 8 зөрчил дутагдал илэрснээс, улсын байцаагчийн хугацаатай 6 албан шаардлага хүргүүлж, гаргасан зөрчлийг дор бүр нь арилгуулж ажилласан. Мөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хууль бус 1 ширхэг хээрийн саарал чоно агнасан төв аймгийн харъяат 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулын арга хэмжээ авч, чоныг улсын орлого болгосон байна.

Тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн байгууллага болох “Хэт-Жолоо” ХХК-ний өдөр тутмын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, 22 м3 мод модон материалд гарал үүслийн гэрчилгээ бичиж олгосон.

Мэргэжлийн хяналтын газраас 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/04 тоот албан бичгийн дагуу хүнсний аюулгүй байдлыг хангуулах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний эрхлэгчийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах, хоол хүнсээр дамжин халдвар, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөмж зөвлөгөөг нийт 31 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, хугацаа дууссан

хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж буй 2 ААН байгууллагад буцаан олголт хийхийг зөвлөн, тус бүтээгдэхүүнийг лангуунд байрлуулах талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 189 дүгээр тогтоолд бүх төрлийн 0,0035мм болон түүнээс дээш нимгэн, нэг удаагийн нийлэг уутыг худалдаа үйлчилгээний сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг хориглох талаар мэдээ мэдээллийг цахим хуудсаар хүргэн ажиллаж байна.

Томуугийн вирус, ханиад буурахгүй байгаатай холбогдуулан 6,7-р ангийн суралцагчдад Сум дундын эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан Ч.Эрдэнэцэцэг “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх нь”, мөн мэс заслын их эмч О.Эрдэнэбулган “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх” зэрэг сэдвүүдээр сургалт хийлээ. Сургалтанд нийт 112 суралцагч хамрагдлаа.

Сургуулийн өмнөх боловсролд хамруулах ажлыг цаг үетэй уялдуулан хүүхдийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр зохион байгуулж байна. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн өдөр тутмын үйл ажиллагаагаар хүүхдэд олгогдох чадваруудыг эзэмшүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна. Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа түр хаагдсантай холбогдуулан бүлгийн багш нар хүүхдүүдээр хийлгүүлэх дасгал, шүлэг, дууг эцэг эхчүүдэд цахимаар өгч ажиллаа.

“Маскаа зүүе” хөдөлгөөний сумын хэмжээнд өрнүүлэн, олон нийтийн газар масктай ажиллаж хэвшихийг уриалан ажиллав. Тус ажлын үр дүнд олон нийттэй харилцдаг ажилтнууд, ЕБС-ийн сурагчид 100% амны хаалт, маск хэрэглэж байна.

Сүхбаатар сум

Гудамж, талбайн, олон нийтийн газар архидан согтуурах, хулгайлах, танхай, дээрэм, гудамж талбайд согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах зорилгоор Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуй нэгж, байгууллагуудыг хамруулан 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд “Нийтийн эргүүл”-ийг ажиллуулах тухай Засаг даргын А/08 тоот захирамжийг гарган 8 аж ахуй нэгж байгууллагын 44 албан хаагч Цагдаагийн газартай хамтран эргүүлд гарч ажиллаж байна.

Тус суманд Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 1-р сарын 07-оос-20-ны өдрүүдэд зохион байгуулж 2-р сарын 05-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабд цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг нэгтгэн хүлээлгэн өгч ажиллалаа. Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлээр Бэлтгэл офицер 107, Бэлтгэл ахлагч 59, Бэлтгэл түрүүч 1189, Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд 149 тус тус бүртгэгдсэн байна.

Тус сумын хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах эрх бүхий 16 албан хаагчийн 2018 оны хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг “ХАСХОМ хүлээн авсан бүртгэл”, Хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл”, Мэдэгдэл, тайлбар, тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл”-ийг тус тус маягтын дагуу цахим системд хуулийн хугацаанд бүрэн тусган, бүртгэж ажиллалаа.

Ахмад настны тухай хуулийн 12-р зүйл 12.5 дахь заалтын дагуу сар шинийн баярыг тохиолдуулан 1-р сарын 29-нд аж ахуй нэгж, байгууллагын харъяалалгүй нийт 953 ахмад настан, 80-84 насны 101 ахмад настанг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа. Мөн аймгийн Засаг даргын гарын бэлгийг 85-аас дээш настай 62 ахмад настанд гардууллаа. Тус арга хэмжээний үеэр Сүхбаатар сумын Засаг дарга 2017-2018 онд хийсэн ажлын товч тайланг танилцуулж, Нэгдсэн эмнэлгийн эмч нар 200 гаруй ахмадад үзлэг хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, Сэлэнгийн Долгио чуулгын уран бүтээлчид уран бүтээлээрээ ахмадууддаа бэлэг барьлаа.

Хонгорморьт 1 дүгээр багийн гахайн аж ахуй эрхлэгч иргэн С.Алтан хуяг гахай олноор үхсэн гэсэн дуудлага өгсний дагуу тус сумын малын эмч нар очиход 26 толгой гахай үхсэн байдалтай байсан. Үхсэн гахайнуудад гадна үзлэг хийхэд “Гахайн Африк мялзан” өвчний сэжигтэй байсныг аймгийн Мал эмнэлгийн газарт мэдэгдэж үхсэн гахайнаас дээж авч Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид хүргүүлэхэд шинжилгээний хариу Гахайн Африк мялзан” өвчин болох нь тогтоогдсон. Үүнтэй холбогдуулан Сумын Онцгой комисс 3 удаа хуралдаж Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай А/31, Хорио цээрийн дэглэм тогтоох тухай А/34, Өвчтэй малыг устгалд оруулах тухай А/35 тоот Захирамжийг тус тус гарган сумын Мэргэжлийн анги, Гамшгаас хамгаалах штабын бие бүрэлдэхүүн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай арга хэмжээ авч ажиллалаа. Нийт 20605 м2 талбай, 1587 авто машинд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, 2 иргэний 27 гахай өвчилж үхсэн. Хонгорморьтын 1 дүгээр багийн 22 өрхийн 253 гахайг устгаж, Гахайн мялзан өвчинтэй тэмцэх зааврын дагуу устгаж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

Сүхбаатар сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын түлшний модоор хангах гэрээг Алтанбулаг, Түшиг, Ерөө, сумдтай хийж, 01 дүгээр сарын 19-өөс Түшиг сумын Хар горхиос 200 иргэнд 800 м3, Алтанбулаг сумаас 70-н иргэнд 350 м3 түлшний мод өгч эхлээд байна. Одоогийн байдлаар 1150 м3 түлшний мод олгоод байна.

Орон нутгийн хөрөнгөөр Орхоны 6-р багт гэрэлтүүлэг тохижилтийн ажил, Аймгийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн Партизаны талбай Цэнгэлдэх хүрээлэнгийн гэрэлтүүлгийн ажил, Ерөнхий боловсролын 1- сургуулийн спорт заалны засварын ажлуудын тендерыг зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажлуудыг эхлүүлэн хүлээн авч байнгын ашиглалтанд оруулаад байна.

2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг баг тус бүрээр эрэмбэлэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орж батлуулсан.

Хүдэр сум:

Тайлант сард сумын Засаг даргын зөвлөлийн хурал 3 удаа хуралдаж, ИТХ-д өргөн мэдүүлэх материалуудыг бэлтгэх тухай болон цагаан сар 2019 үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сумын ажил мэргэжлийн 9 алдартан тодруулах тухай, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа. 2018 оны аварга байгууллагаар Г.Цэрэндамба даргатай ЗДТГ-ын хамт олон, аварга аж ахуйн нэгжээр С.Эрдэнэбат захиралтай “Цэлмэг Хүдэр” ХХК, аварга төрийн албан хаагчаар ЕБСургуулийн бага ангийн багш М.Энхтүвшин, аварга сурагчаар 10-р ангийн сурагч Ө.Ганбаяр, аварга малчинаар Д.Галхүү, аварга өрхийн үйлдвэрлэл эрхлэгчээр Л.Анхбаяр, аварга худалдаа үйлчилгээний ажилтанаар Э.Бадамхүү, аварга, аварга спортын алдартнаар Ж.Эрхэмбаяр, аврага ХАА-н ажилтнаар Ц.Цэнбумаа нар тус тус шалгарч шагналуудыг сар шинийн өмнө гардуулан өглөө.

Тус сумаас 2018 онд Улсын аврага малчин 1, аймгийн аврага малчин 1 төрж шагналыг УИХ-ын гишүүн Н.Оюундарь, Аймгийн Засаг дарга Ш.Оргил болон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, сумын удирдлагууд гардуулан өглөө.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сумын ЗДТГ-ын өргөтгөлийн барилгын нээлтийг хийж, ашиглалтанд хүлээн авлаа.

Суманд “Цагаан сар-2019” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 16 иргэн, сүү, цагаан идээ, даршилсан ногоо, мах, махан бүтээгдэхүүн, монгол дээл зэрэг үзэсгэлэнг гаргаж 110 иргэн хамрагдаж 5,0 сая төгрөгийн худалдаа хийгдсэн байна. Суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллага нийт 166 ахмад настанд хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулж өгсөн.

Сумын сургууль нь 2019 онд удирдах ажилтан 4, багш 32, ажилтан 16, 1-11-р ангийн 22 бүлэгт 531 суралцагч суралцаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрөөр хэрэгжсэн “Монгол ёс заншлаа өвөлөхүй” сэдвийн хүрээнд 2-р сарын14-нд “Дээлтэй Монгол” өдөрлөгт 104 хүүхэд 5 эцэг эх, багш ажилтан оролцож Монгол хувцас, эд

хэрэглэлээр гоёж өөрсдийн насны онцлогт нийцсэн агуулгаар Ардын ёс заншлаас суралцаж, сурч эзэмшсэн чадвараа эцэг, эхчүүд хамтарч ажилласан.

“Малчдын эрүүл эрүүл мэндийг дэмжье” үндэсний хөтөлбөрийн хүрээнд их эмч Б.Энхбат, лаборант Д.Нансалмаа нар 9 малчин өрхийн 23 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг, элэгний В,С вирус, чихрийн шижин илэрүүлэх шинжилгээ хийж томуугаас сэргийлэх сурталчилгаа, зөвөлгөө өгч эм бэлдмэлээр үйлчиллээ.

Дархлаажуулалтад хамрагдвал зохих 66, явуулын түр оршин суугчдын 8 хүүхдийг тус тус дархлаажуулалтад хамрууллаа.

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед мэдээллийн самбар, Эрчим, Тансаг худалдааны төвийн мэдээллийн самбарт нааж эцэг, эхчүүд асран хамгаалагч нарт мэдээлэл өгч байна. Байгууллагын мэдээллийг урсдаг самбараар цаг үеийн өвчлөлийн байдал, иргэдэд зам тээврийн болон ахуйн осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж зөвөлгөө, сэрэмжлүүлгийг байнга түгээж мэдээлэл хүргэж байна.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах, Сүрьеэгүй Сэлэнгэ аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 онд хяналтад орсон үргэлжлэх шатны эмчилгээтэй 3 эмчлүүлэгч хасагдаж одоо 2 эмчлүүлэгч үргэлжлэх шатны эмчилгээгээ хийлгэж байна. Сүрьеэгээр өвчлөгсдийн 7 хүүхдэд туберкулины сорилыг тавьж сүрьеэгийн диспансерт мэдээг өгсөн.

Тайлант сард ажил хайгч иргэнээр 6 иргэн бүртгүүлж 1 иргэнг ажлын байранд зуучилж ажиллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогддог зээлийн эргэн төлөлтөө хугацаандаа төлөөгүй иргэн Г.Цэцэгбаатар 500,0 төгрөг, Л.Долгорсүрэн 480,0 мянган төгрөг, Ж.Сэргэлэнчимэг 2000,0 төгрөгийг нөхөн барагдуулахад албан шаардлага өгч барагдуулаад байна.

Сар шинийн баярыг тохиолдуулан хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх тухай албан бичгийг сумын уяачдын холбоонд хүргүүлэн ажилласан.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжиж байгаа ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төсөл хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн талаар 32 иргэнд мэдээлж ажиллаа.

“Марс нуга” мал эмнэлэгтэй хамтран 26 гахайтай өрхөөр явж гахай нэг бүрийг үзлэгт хамруулан тандалт хийж гахайн эзэнд өвчний талаар дэлгэрэнгүй тайлбар өгч гахайн байр ойр орчныг цэвэрлүүлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа. Гахайн африк мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж сэрэмжлүүлэг, гарын авлагуудыг албан байгуулагууд болон хүнсний дэлгүүрийн зарлалын самбарт байршуулж, цахим фэйсбүүк “Хүдэр зарын групп” болон бусад цахим хаягаар байршуулсан.

2019 онд газар тариалангийн үйлдвэрлэлд шаардагдах хор, бордоо үрийн захиалгыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, нөөцөлсөн үрийг лабораторийн шинжилгээнд хамруулах арга хэмжээ авлаа.

Хушаат сум:

"Улсын аварга тариаланч хамт олон"-оор Хушаат сумын "Мо Мо Агро" ХХК-ний болон "Аймгийн аварга тариаланч хамт олон"-оор Хушаат сумын "Ар Сэвд Могой" ХХК, "Аймгийн аварга фермер"-ээр "Нью кроп" ХХК-иуд Б.Анхбаяр, "Аймгийн аварга ногоочин"-оор иргэн М.Баярхүү, "Аймгийн аварга малчин"-аар малчин Б.Ананд нар шалгарсныг аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог нар гардуулан өглөө. Мөн Монголын Үндэсний олон нийтийн телевизийн нэрэмжит "Алтан төлийн эзэн"-ээр шалгарсан Хушаат сумын малчин Д.Алтансүхэнд сумын удирдлагууд шагналыг гардууллаа.

Сар шинийн өмнөхөн ажил үйлсээрээ тэргүүлж яваа сумын аваргууддаа хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа боллоо. "Сумын аварга ногоочин"-оор Л.Буяндалай, "Сумын аварга тариаланч"-аар Г.Энхтайван, "Сумын аварга малчин"-аар Ц.Ганзориг, Ё.Дулмаа, Т.Пүрэвсүрэн, Намжилсүрэн нар, "Сумын аварга туслах малчин"-аар

С.Нацагдорж нар шалгарч сумын аваргуудын шагналыг сумын Засаг дарга Б.Атартулга, Засаг даргын орлогч Г. Галбадрах нар гардуулж хүндэтгэл үзүүллээ.

XVII жарны Урвуулагч хэмээх шороон гахай жилийн сар шинийн баярт зориулсан үндэсний бөхийн барилдаанд аймаг, сумын цолтой болон залуу 24 бөх барилдсанаас Хушаат сумын харьяат аймгийн начин Б.Хүдэрбаатар түрүүлж, Дархан уул аймгийн харьяат аймгийн харцага Д.Бадрал 4 даван үзүүрлэлээ. Мөн сар шинийн өмнө сумын төвийн иргэдийг цагаан идээгээр хангах, ЖДҮ –ийг бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжих зорилгоор жил бүр “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулж 12 хүн оролцлоо.

УИХ-ын 2019.02.01-ний өдрийн 21 тоот тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам", МУЗГ-ын 2019.01.23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" -ийг сумын ЗДТГ-ын цахим Fb хуудаст байршуулж хэрэглэгчид 2500,1700 удаа хуваалцаж нийтэд мэдээллээ.

Үндсэн хуулийн 27 жилийн ой, Шинэ Үндсэн хууль батлалцсан сумын анхны Засаг дарга, АИХ-ын депутат асан Х.Намсрайжав агсны нэрэмжит Шатрын тэмцээнийг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж тэргүүн байранд 8-а ангийн сурагч М.Энгүүн, дэд байранд 9-а ангийн сурагч Г.Ганхүү, гутгаар байранд 9-а ангийн сурагч Б.Батжаргал нар шалгарлаа. Үндсэн хууль, Монгол хэлний тухай хуулийг сурталчлах арга хэмжээний хүрээнд "Шинэ Үндсэн хууль" видео сургалт, Монгол хэлний тухай хуулиар гарын авлага бэлтгэн багш нар болон ангиудад тараан суртчилгааны ажлыг зохион байгууллаа.

Сумын Соёлын төвөөс морин хуур, бүжгийн дугайланг хичээллүүлж 25 хүүхдийг хамруулж байгаа бөгөөд иргэдийн дунд “Би жингээ хасмаар байна” гимнастикийн дугуйланг хичээллүүлж нийт 12 хүн оролцсон ба эдгээр иргэдийнхээ дунд бүжгийн уралдаан зохион байгуулж Ц.Отгонжаргал түрүүлжээ.

Сумын ЭМТ-өөс зохион байгуулсан “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сарын аян”-д идэвхтэй оролцон Орхон хорооллын 1 худгийн мөсийг цохиж иргэдийнхээ аюулгүй байдлыг ханган ажиллалаа. Орон нутаг судлах танхим улсын нэгдсэн тооллогод бэлтгэн соёлын биет болон биет бус өвийн судалгааг гаргалаа. Энэ сард орон нутаг судлах танхимаар нийт 41 хүн үйлчлүүлээ.

Халамжийн үйлчилгээний чиглэлээр энэ сард 113 иргэнд 5.494.710 төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгон шинээр 6 хүүхдийн мэдээлэлийг мэдээллийн санд шивж хүүхдийн мөнгөнд хамрууллаа.

Энэ сард сумын ЭМТ-д нас баралт 2, ор хоног 135, эмнэлэгт хэвтсэн 15, эмнэлгээс гарсан 12 үзлэгийн тоо бүгд 165, үүнээс: амбулатори 90, урьдчилан сэргийлэх 30, идэвхитэй хяналт 10, гэрийн идэвхитэй үзлэг 35, хяналтанд байгаа жирэмсэн 22, шинээр хяналтанд орсон 2, халдварт бус өвчин 10, 0-5 насны жинэлсэн хүүхдийн тоо 40, түргэн тусламжийн дуудлага 40, үүнээс алсын дуудлага 8, артерийн гипертензи эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 5, чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо 5, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүүхдийн тоо 27, шинжилгээнд хамрагдсан хүний тоо 15, элэгний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 5 байна.

ЕБСургууль багш нартаа зориулан “Сургалтанд ашиглах цахим хэрэглэгдэхүүн бэлдэх болон сургалтанд ашиглах үнэгүй программ” 5 хоногийн сургалт, “Хичээл сургалтын үйл ажиллагаанд тусгах нь” 2 өдрийн сургалт, “Багшийн хөгжлийн хууль”, “Багшийн ёс зүй”, “Зөрчлийн тухай хууль”, “Хүүхэд хөгжлийн хууль”, “Төрийн албаны тухай хууль” “Бага ангийн багшийн байгалийн ухааны хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй” сургалтуудыг зохион байгууллаа. Мөн анги даасан багш нар сурагчдыг гэрээр эргэлт хийн даалгавараа хэрхэн зөв хийх талаар зөвлөмж өгч эцэг эхчүүдтэй хамтран ажиллалаа. 2-р сарын 13-нд “Дээлтэй Монгол” өдөрлөг зохион шагай няслах, шагай шүүрэх, алаг мэлхий, морь уралдуулах 4 төрлийн тэмцээнийг явуулж сурагчдыг үндэсний тоглоом наадгайгаар тоглуулж ёс заншлаа таниулж ажиллав. НТББ П.Энхбат, түүх нийгмийн багш Хажидсүрэн нар “Алжаал тайлах 10 агшин” 3 төрлийн тэмцээнийг явууллаа. Мандал сумын Эко 3-р сургуультай “Туршлага судалж хамтдаа

хөгжицгөө” аян өрнүүлэн багш нар амжилттай оролцлоо. НТБН-ээс ард иргэдийн санхүүгийн ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Өрхийн төсвөө хэрхэн зөв удирдах вэ” “Ашигтай зээл гэж юу вэ” сургалтуудыг ХААН банктай хамтран зохион байгуулж нийт 58 иргэн хамрагдлаа. Мөн иргэдийн дунд “Архины хор уршиг” сургалтыг зохион байгуулж жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Архи амьдралын дайсан” АСТ-ийг явуулахаар удирдамжийг батлуулж байгууллага, багуудад тараагаад байна. Энэ сард аймгийн төвд зохион байгуулагдсан Орос хэлний олимпиадын 2-ын даваанд багш Л.Отгонбаяр 9-а ангийн сурагч Г.Ганхүүг бэлтгэн амжилттай оролцлоо.

2019 оны хаврын тариалалтанд шаардагдах үр, шатахуун, хор, гербицид, бордооны хэрэгцээ, захиалга мөн тариалах талбай, таримлын төрөл, бэлэн байгаа болон дутагдах үрийн төлөвлөгөө захиалга, техник тоног төхөөрөмжийн судалгааг авч нэгтгэн сумын 2019 оны газар тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг эхлүүллээ. Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир бэлтгэн тушаасан малчин мал бүхий иргэнд мөнгөн урамшуулал олгох, хяналт тавих, тайлагнах журмыг хэрэгжүүлэн арьс шир бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан 120 малчин мал бүхий өрхийн 243 баримтыг хүлээн авч, хянан шивж жагсаалтыг баталгаажуулан дээд байгууллагад хүргэж ажиллалаа. Өнгөрсөн жилийн урамшуулал нь ороогүй 29 малчны мэдээллийг хянан дээд байгууллагад хүргүүллээ.

Гахайн африк мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг хүргүүлэн ариутгал халдваржүүлэлт хийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллав.

Малын генетик нөөцийн хуулиар нийт 100 малчинд мэдээлэл өгч гарын авлагаар хангалаа.

Түшиг сум:

Билгийн тооллын хаврын тэргүүн сар цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан газар тариалан, мал аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажиллаж, ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлан ажилласан иргэдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. “Сумын аварга малчин”-аар Т.Эрдэнээ, Д.Батхүү, “Аварга саальчин”-аар Д.Отгонжаргал, “Аварга тариаланч”-аар Ө.Ууганзаяа “Татвар төлөгч малчин”-аар П.Магсаржав нар тодорлоо.

Аймгийн Засаг даргын гарын бэлгийг өндөр настан Г.Пүрэвсүрэн, Ж.Моголцог, Ш.Даваа нарт гардуулж, сумын Засаг даргын гарын бэлгийг 70-аас дээш 39 ахмад настанд гардуулж, хүндэтгэл үзүүллээ. Мөн Ахмад настны тухай хуулийн дагуу 30 аж ахуйн нэгж, байгууллагуудад нийт 157 ахмад настанг хариуцуулан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

Төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг малчдад хүргэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх, нүүдлийн номын сангийн үйлчилгээг хүргэх зорилгоор 2 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд “Явуулын Иргэний танхим”-ын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгууллаа. Үйлчилгээнд Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Мал эмнэлэг, үржлийн нэгжүүд нийт 12 албан хаагч оролцож, хөдөөгийн 45 малчин өрхийн 130 гаруй иргэдэд үйлчиллээ.

Төрийн албаны тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай 3 төсвийн шууд захирагч, ЗДТГ-ын даргатай төрийн захиргааны 9 албан хаагч “Үр дүнгийн гэрээ”-гээ байгууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдөр төр төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нар болон орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээ, цаг үеийн мэдээллийг хийлээ.

Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, нийт 18 албан хаагчийг 13 төрлийн үзлэг шинжилгээнд хамрууллаа.

Аж ахуйн нэгж, иргэдээс төмс 50кг, улаан буудайн дээжийг авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ. Гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх

үүднээс мал эмнэлэг, үржлийн нэгжүүдтэй хамтран хяналтын цэгт байршуулж, гаднаас орж ирж буй тээврийн хэрэгслүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, гахай тэжээдэг 4 өрхөд санамж, анхааруулах хуудас тараалаа.

Хаврын хуурайшилтийн үе эхэлж байгаатай холбогдуулан 23 өрхийн 80 гаруй өрхөд анхааруулах хуудас тарааж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 74 тоот тогтоолоор батлагдсан “Сумын газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Энэ сард эмнэлэгт 21 хүнийг хэвтэн эмчилж, 3 эх төрснөөс сумандаа 2, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд 1 эхийг төрүүлсэн. Одоогийн байдлаар жирэмсний хяналтанд 12 эх байна. Товлолт дархлаажуулалтанд 26 хүүхэд хамрагдаж, дархлаажуулалтын дараах хүндрэл гараагүй. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 151 өрхийн 504 хүнд зөвлөгөө өгч, 78 ширхэг гарын авлага тарааж, Засаг даргын Тамгын газартай хамтран хөдөөгийн 21 өрхийн 79 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 18 ширхэг гарын авлага тарааж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 2-3 ээлжийн амны заалт зүүлгэн хэвшүүлж, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгууллаа.

Шаамар сум:

ХҮИ дугаар жарны “Урвуулагч” хэмээх шороон гахай жилийн Хаврын тэргүүн сарын Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан сумын Засаг даргын 2019 оны 01 сарын 23-ны өдрийн “Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай” А/07 тоот захирамжийн дагуу орон нутагт амьдарч буй ахмад настнуудад харъяалах аж ахуй нэгж байгууллагууд хүндэтгэл үзүүлж гарын бэлгийг гардуулан өглөө. Нийт 299 ахмад настанд хүндэтгэл үзүүллээ.

Төрийн байгууллагын албан хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйн харилцааг сайжруулах, ур чадварыг нэмэгдүүлэн төрийн байгууллагын уялдаа холбоог дээшлүүлэх зорилгоор Дулаанхаан тосгоны “Төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөн”-ийг 2019.02.01-нд зохион байгуулж нийт 100 гаруй албан хаагчид хамрагдлаа. Мөн ДЗМОУБ-ийн Сэлэнгэ НХ-ийн дэмжлэгээр төрийн албан хаагчдад “Төрийн албан хаагчийн манлайлал-хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Шаамар сумын 2019 оны улаан буудай тариалах иргэн , аж ахуй нэгжийн тариалах талбай, шаардагдах үр, бордоо, ургамал хамгааллын бодисын захиалгыг хавсралт хүснэгтийн дагуу нэгтгэн гаргаж Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2019 оны 01 сарын 15-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” 01 тоот албан даалгаврын хүрээнд Сумын Засаг даргын А/05 тоот захирамжаар урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Мал эмнэлэг үржлийн нэгжийн эмч нар болон ХАА-н тасгийг мэргэжилтэн болон багийн Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган, ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Сумын хэмжээнд гахайн аж ахуй эрхэлж буй 1 аж ахуй нэгж байгууллага, 5 өрхийн 112 гахайн судалгааг гаргаж үзлэг тандалт хийн, иргэдэд гахайн мялзан өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөө өгч, гарын авлага, боршур тараан ажиллалаа. Аймгийн Мал эмнэлгийн газраас 25 кг хлорын шохой, Мал эмнэлэг үржлийн нэгжээс 115 литр “ЭКОЦИТ ” уусмалаар гахайн байрны 587 мкв талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж халдваргүйжүүлэн гахайн байруудад гутал ариутгах цэгийг хийлгэж гахайн маллагаанд тогтмол мөрдөж ажиллахыг даалгасан. Гахайн мялзан өвчний дэгдэлт болон хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сумын цахим хуудсанд мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж, хүнсний дэлгүүрүүд болон, гадаа мэдээллийн самбарт мэдээлэл тавьж иргэдийг мэдээллээр ханган ажиллав.

2018 оны жилийн эцэст тоологдсон төллөх насны 10601 толгой хээлтгчээс 2 дугаар сарын байдлаар 90 толгой мал төллөж төл бойжилт 100% байна. Энэ сарын байдлаар хорогдсон малын тоо 7 бүртгэгдсэнээс 4 хээлтгэгч хорогдсон байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2-р сарын 13-ны өдрийн 1/113 тоот албан бичгийн хүрээнд сум орон нутгийн хэмжээнд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуй нэгж болон тохирлын гэрчилгээтэй аж ахуй нэгжийн нэгдсэн судалгааг гарган стандарт хэмжилзүйн газарт хүргүүлсэн.

Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн, хүнсний эрүүл ахуйн чанар, хаяг шошгон дээр хяналт шалгалт хийж үйлдвэрлэсэн хугацааг шалгаж хяналт тавьж ажиллахад зөрчилтэй бараа бүтээгдэхүүн илрээгүй болно. Сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, 18 дугаар цэцэрлэг, Баясгалант ирээдүй 2 дугаар цэцэрлэг, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн өдрийн хоолны хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл лабораторын шинжилгээ өгсөн эсэх, чанар, амтанд амталгаа хийж гурван удаагийн байдлаар хяналт тавьж ажиллахад зөрчил илрээгүй.

Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хийгдсэн хяналт шалгалтын хүрээнд Хүдэр суманд мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ойн санг гэрээгээр эзэмшдэг 6 мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн явцад хяналт шалгалт хийж, мод бэлтгэлийн аж ахуйн нэгж, байгууллагууд мод тээврийн хяналтын хуудсыг бүрэн бөглөж хэвшээгүй, ажлын байранд байх ёстой чухал шаардлагатай албан бичиг, холбогдох баримт материалыг байршуулдаггүй, ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилладаггүй, мөрдөж хэвшээгүй зэрэг дутагдал илэрснийг засуулах арга хэмжээг авч байна. Сумын хэмжээнд айл өрх болон гудамж талбайд эргүүл шалгалтыг хийхэд нийт 19 байршилд 200 гаруй ширхэг нойтон нарсан гуалин байсныг Хүдэр сумын байгаль хамгаалагч, ойн техникч нарыг байлцуулан тоолж хэмжиж фото зургаар баталгаажуулан хүлээлгэн өгсөн.

Нийгмийн даатгалын болон халамжийн тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгосон.

БОЛОВСРУУЛСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ж.САЙНЦОГ